



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • X • № 38

Н.БАЯРТСАЙХАН:
**МӨНГӨНИЙ ЗОХИСТОЙ
БОДЛОГООР
ТОГТВОРТОЙ ЭДИЙН
ЗАСГИЙГ ДЭМЖИНЭ**

**МОНГОЛБАНКНЫ
БОДЛОГО, ҮЙЛ
АЖИЛЛАГААНД
ШИНЭЧЛЭЛ
АВЧ ИРСЭН ОН
ЖИЛҮҮД**



ЗӨВХӨН АЛБАН ХҮЭРЭГЦЭЭНД

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН
САНГААС: НОГООН ДАРА ЭХ

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛМАА



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг олон нийтэд танилцуулах энэ удаагийн хэлэлцүүлгийг “Эдийн засгийн төлөв-Мөнгөний бодлого” сэдвийн хүрээнд хийв. 2020 онд баримтлах мөнгөний бодлого нь гадаад өрийн удирдлагыг сайжруулах, эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Мөн ирэх онд гадаад, дотоод секторын тэнцвэртэй байдлыг хангах, валютын ханшийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, инфляцийг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ. Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга

хэрэгслийг Базелийн стандарттай нийцүүлэн сайжруулж, банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг үргэлжлүүлэх бөгөөд банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн шинэтгэлийг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлж, холбогдох хуулийн төслийг боловсруулна. Технологийн дэвшилттэй холбоотойгоор санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулахыг зорьж буй тухай уг хэлэлцүүлгийн үеэр танилцууллаа.



Онцлох үйл явдал:

ХУУДАС

Бүсийн математикийн
олимпиадын тэргүүлэгч
аймгуудад Монголбанкны
шилжин явах цом олгоно

4

Ярилцлага:

ХУУДАС

Н.Баяртсайхан: Мөнгөний
зохистой бодлогоор
тогтвортой эдийн засгийг
дэмжинэ

6

Асуулт, хариулт:

ХУУДАС

"ТМБҮЧ-2020" хэлэлцүүлгээс

11

Байр суурь:

ХУУДАС

Гадаадын хөрөнгө оруулалтыг
хэрхэн нэмэгдүүлэх вэ?

20

Нийтлэл:

ХУУДАС

Монголбанкны бодлого, үйл
ажиллагаанд шинэчлэл
авч ирсэн он жилүүд

24

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Төв банкуудын хэрэгжүүлж буй
мөнгөний бодлого

28

Инфографик:

ХУУДАС

Төв банкуудын бодлогын хүү

30

**Монголбанкны
Эрдэнэсийн сангаас:**

ХУУДАС

Ногоон Дара эх

32

Банкир:

ХУУДАС

Нэн тэргүүнд хөрөнгө
оруулагчдын итгэлийг
нэмэгдүүлэх шаардлагатай
байна

33

**Мөнгөн тэмдэгтийн
түүх:**

ХУУДАС

Дурсгалын зоос

37

Судалгаа, шинжилгээ:

ХУУДАС

Монгол Улсын төлбөрийн
тэнцлийн 2019-2020 оны
төсөөлөл

38

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Хуримтлал яагаад хэрэгтэй вэ?

41

Бүсийн математикийн олимпиадын тэргүүлэгч аймгуудад Монголбанкны шилжин явах цом олгоно

2019.10.07

Монголбанк Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд орон нутагт буй оюуны чадавхийг эрт нээн илрүүлж, хөгжүүлэх, ирээдүйн чадварлаг боловсон хүчний нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн бүсийн математикийн олимпиадыг Монголын математикийн олимпиадын хороотой хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар боллоо. Монголын математикийн олимпиадын хорооноос 21 аймгийн газар нутгийн байдал, өрсөлдөх чадвар зэргийг харгалзан 4 бүсэд хувааж, бүсийн олимпиадыг 10 дугаар сард улс орон даяар нэгэн зэрэг зохион байгуулдаг болоод 5 дахь жилтэйгээ золгож байгаа юм. Цаашид бүсийн математикийн олимпиадыг тогтвортой явуулах, нэр хүнд, ач холбогдол, цар хүрээг өргөтгөх чиглэлд Монголбанкнаас хамтран ажиллах бөгөөд бүсдээ тэргүүлсэн аймагт "Монголбанкны Ерөнхийлөгчийн нэрэмжит шилжин явах цом" олгохоор болов.



Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал болов

2019.10.07



Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр боллоо. Хурлаар Монголбанкны санхүүгийн тайлагналын олон улсын шинэ стандартын хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл сонсов. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9 (СТОУС9)-г Монголбанкны санхүүгийн тайлагналд нэвтрүүлэх бэлтгэлийг хангах ажлыг сайтар зохион байгуулж, гадаад, дотоодын экспертүүдтэй хамтран ажиллаж, сургалт судалгаа хийн ажилласны үр дүнд тус стандартыг 2018 оноос амжилттай хэрэгжүүлж эхэлжээ. Хөндлөнгийн аудитын байгууллага "Прайсуотерхаус Куперс Аудит" ХХК-аас 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Монголбанкны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтэд "санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна" гэжээ.

Эссэ бичлэгийн уралдааны ялагчдад шагнал гардууллаа

2019.10.08

Банкны хөгжил дэвшил, түүний үйл ажиллагааны талаарх харилцагч болон иргэдийн ойлголт, харилцагчийн эрх ашгийг хамгаалахад харилцагчдаас хөндөж буй асуудал зэргийг тандан мэдэх зорилгоор "Хариуцлагатай харилцагч-Хариуцлагатай банк" аяны хүрээнд эссэ бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдааны оролцогчид нь тоо баримтад тулгуурласан, үндэслэл, судалгаатай, бодит байдлыг эрэлхийлж, дүгнэлт гаргасан, асуудал хөндсөн байх зэрэг шалгуур дор бүтээлээ ирүүлэв. Нэг сарын хугацаатай зарласан энэхүү уралдаанд нийт 100 гаруй бүтээл ирүүлснээс тэргүүн байранд СХД-ийн 22-р хорооны иргэн Ч.Хонгорзул шалгарч удаах байруудад ХУД-ийн 2-р хорооны иргэн Б.Ананд, БЗД-ийн 14-р хорооны иргэн Н.Амартүвшин нар шалгарлаа.



Монголбанкны Ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид ОУВС, Дэлхийн банкны 2019 оны жилийн уулзалтад оролцлоо

2019.10.24

Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн банкны захирлуудын зөвлөл болон гишүүн орны Төв банкны тэргүүн, Сангийн сайд, Парламентын гишүүд, судлаачид жил бүр чуулж Дэлхийн эдийн засгийн чиг хандлага, тулгарч буй сорилтуудын талаар хэлэлцдэг уламжлалтай билээ. ОУВС, Дэлхийн банкны Захирлуудын зөвлөлийн Жилийн уулзалт 2019 оны 10 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо боллоо. Тус уулзалтад Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан тэргүүтэй төлөөлөгчид оролцож, ОУВС, АНУ-ын Сангийн яам болон албаны бусад хүмүүстэй уулзаж Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, цаашид хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ, хамтын ажиллагааны талаар санал солилцов.



Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх анхны зөвшөөрлийг ХасБанк авлаа

2019.10.25

Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”-ыг үндэслэн Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг анх удаа ХасБанканд олголоо. Энэхүү зөвшөөрлийг гардуулах арга хэмжээ 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монголбанкны хүндэтгэлийн танхимд боллоо. Тус арга хэмжээнд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Хяналт зохицуулалтын хэлтсийн захирал Ц.Алдармаа, ХасБанкны Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав, Цахим шилжилтийн газрын захирал С.Мөнхболд нар оролцов.



Банк, санхүүгийн байгууллагууд дэлхийн хуримтлалын өдрийг тэмдэглэв

2019.10.31



Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, ХБНГУ-ын Остпригнитц-Руппины Шпаркассэ банк, арилжааны 13 банк хамтран “Хариуцлагатай харилцагч, хариуцлагатай банк” аяны хүрээнд “Хэмнэе, хуримтлуулъя” уриатайгаар 10 дугаар сарын 31-ний өдөр “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийг Улаанбаатар хотноо, Монголын хүүхдийн ордонд тэмдэглэлээ. Нээлттэй арга хэмжээний үеэр банкууд хүүхэд багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажиллав. Түүнчлэн Монголбанк болон ХБНГУ-ын Шпаркассэ банкны сангийн зүгээс хуримтлал үүсгэхийн ач тус давуу талыг танилцуулсан гарын авлага, ном товхимлуудаа хүүхэд багачуудад танилцууллаа.

Н.БАЯРТСАЙХАН: МӨНГӨНИЙ ЗОХИСТОЙ БОДЛОГООР ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИНЭ




Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы Төв банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын арга хэлбэр, бодлогын үр дүн, эдийн засгийн цаашдын төлөвийн талаар Форбес Монголиа сэтгүүлийн 2019/08/09-ний 62 дахь дугаарт гарсан ярилцлагыг хүргэж байна.

Олон улсад төв банкууд "үнийн тогтвортой байдал" гэдэг зорилтод чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байна. Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлогын арга хэлбэрийн талаарх асуултаар ярилцлагаа эхэлцгээх үү?

Орчин үед төв банкуудын мөнгөний бодлогын үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдал буюу нам дор түвшний, хэлбэлзэл багатай инфляци болж байна. Энэ нь эдийн засаг тогтвортой байх нэг суурь бөгөөд, мөнгөний бодлогоор эдийн засагт оруулах гол хувь нэмэр юм. Төв банкууд энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд "инфляцийг онилох бодлого"-ыг хэрэгжүүлдэг. Монголбанк бодлогын арга хэлбэртээ

үндсэн элементүүдийг нь нэвтрүүлээд, хэрэгжүүлээд явж байгаа. Үүнд статистик тоон мэдээлэл цуглуулах арга барилаас эхлээд судалгаа шинжилгээний аргачлал, шийдвэр гаргах оновчтой процесс, бодлогын шийдвэрээ зах зээлд оролцогчдод тайлбарлаж хүргэх сувгууд багтдаг. Мөнгөний бодлогын стратегийн хувьд ирээдүйд чиглэсэн, зах зээлийн зарчимд суурилсан, эрэлтийн гаралтай инфляцийг зохистой түвшинд удирдахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд түүхэн хугацаанд Төв банкны зорилтоос хэт дээш эсвэл доош хэлбэлзэж ирсэн инфляци сүүлийн 2 жилд зорилтот түвшний орчимд тогтвортой хадгалагдлаа (Зураг 1). Энэ бол маш чухал үр дүн юм.



Зураг 1. Инфляцийн хэлбэлзэл 2017 оноос буурч, Төв банкны зорилтот түвшний орчимд тогтвортой хадгалагдаж байна

Зах зээлд гажуудал үүсгэж, төлбөрийн тэнцэл дээр том дарамт болж байсан төсвийн шинжтэй үйл ажиллагааг хумьж, үнийн тогтвортой байдалд чиглэсэн бодлогыг Монголбанк олон улсын нийтлэг зарчмаар хэрэгжүүлсний үр дүн ийнхүү илэрч байна. Сүүлийн 10 гаруй жилд дунджаар 10% давж байсан инфляци 8%-ийн орчимд ийнхүү тогтвортой хадгалагдсан нь цаашид инфляцийн зорилтыг алгуур 6% руу буулгах үндэс болох юм. Үүнд мэдээж төсвийн сахилга бат болон валютын урсгалын тогтвортой байдал чухал нөлөөтэй.

-2016 оны сүүлээр эдийн засаг дефляцид ороод байсан. Харин одоо 8% орчмын инфляцийн төлөвт шилжихэд юу нөлөөлөв? Зарим сард үнийн хэлбэлзэл өндөр байгааг хэрхэн тайлбарлах вэ?

Үнэ бол зах зээлийн эдийн засгийн маш чухал индикатор, дохиологч үзүүлэлт юм. Үнийн өөрчлөлт нь нэг талаас иргэдийн худалдан авах чадвар хэр сайн байгааг, нөгөө талаас аж ахуйн нэгжүүдийн борлуулалт ямархуу байгааг илэрхийлдэг. Үүнийг түүхэн хугацаанд олон жишээнээс харж болно. Тухайлбал, эдийн засагт хүндрэл нүүрлээд байсан 2009 он болон 2014-2016 онуудад инфляци буурах хандлагатай байв. 2016 оны сүүл үеэр дефляци үргэлжилсэн сарууд хүртэл ажиглагдсан. Дефляци манай эдийн засгийн хувьд ердийн үзэгдэл биш бөгөөд өрхийн орлого хумигдаж, зах зээл дээр борлуулалт муудаж, үнэ өсөх дарамт бага болсны илрэл юм. Эсрэгээрээ, эдийн засаг хурдтай өссөн 2011-2012 онд инфляци өсөх дарамт өндөр байв.

Харин сүүлийн 2 жилд буюу 2017 оны 2 дугаар хагасаас хойш эдийн засаг сэргэснээр дефляциас гарч, инфляци алгуур нэмэгдэн Төв банкны зорилтот түвшинд ойртож ирлээ. Энэ нь унаж явсан эдийн засгийг тогтворжуулж, бодит эдийн засгийг дэмжихэд мөнгөний бодлого үүргээ гүйцэтгэсний илрэл болж байна.

Харин өнгөрсөн улиралд нийт инфляцийн 30-40% нь мах, бензин, гэр хороололд хэрэглэдэг түлш зэрэг цөөн бараа бүтээгдэхүүний үнийн нийлүүлэлтийн шалтгаантай хурдтай өсөлтөөр тайлбарлагдлаа. Үүнд мөнгөний хатуу бодлогоор хариу үзүүлэх нь нийт эдийн засгийг сааруулах нөлөөтэй тул оновчгүй юм. Мөнгөний бодлого аль нэг бараа бүтээгдэхүүний үнийг тодорхой түвшинд тогтоох бус, үнийн ерөнхий түвшин эдийн засгийн идэвхжилтэй хэрхэн уялдан өөрчлөгдөж байгаад голлон анхаардаг. Нийлүүлэлтийн шалтгаанаар үнэ нь хурдтай өсч, иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа бүтээгдэхүүнүүдэд Засгийн газраас зохицуулалт хийж байгаа нь инфляцийн төлөвт эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна. Үнийн өсөлт үйлдвэрлэлийн хөгжил, зах зээлийн дэд бүтцийн үр ашгаас хамаарч байгаа энэ тохиолдолд мөнгөний бодлогоор биш, харин нийлүүлэлт талын зохицуулалт шаардлагатай.

-Мөнгөний бодлого үнийн динамикт хэрхэн нөлөөлж байна вэ? Мөнгөний бодлогын эдийн засагт нөлөөлөх шилжих механизмын талаар уншигчдад маань тайлбарлаж өгнө үү?

Мөнгөний бодлого эдийн засагт эрэлт талаас нь нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл хэрэглээ, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны идэвхжилд нөлөөлөх замаар нийт эдийн засгийн идэвхжилд нөлөөлдөг гэсэн үг. Ингэхдээ банкны зээл олголт, зээлийн хүү, ханш, хүлээлт, риск аппетит, хөрөнгийн үнэ зэрэг гол сувгуудаар дамжина. Мөнгөний бодлогын шилжих эдгээр гол сувгууд нь Монголд санхүүгийн зах зээл банкинд суурилдаг онцлогтой ихээхэн холбоотой. Иймд санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх нь мөнгөний бодлогын шилжих механизм үр дүнтэй ажиллахад маш чухал юм. Мөнгөний бодлогын гол хэрэгсэл болох бодлогын хүү нь нийт эдийн засагт нөлөөлдөг, нэлээд хүчтэй хэрэгсэл учраас макро зохистой бодлогын арга хэрэгслийг хослуулж хэрэглэн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдээр банкны салбарт тухайлсан зарим эрсдэлийг хязгаарлах бодлогыг давхар хэрэгжүүлж байна. Ингэснээр санхүүгийн системд эрсдэл хуримтлуулахгүй байх, мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх зорилготой юм.


Үнийн тогтвортой байдалд чиглэсэн мөнгөний бодлогод инфляцийн түвшин зах зээлд оролцогчдын хүлээлт болон үйлдвэрлэлийн зөрүү буюу эдийн засгийн бодит идэвхжил болон потенциал түвшний зөрүүгээр тодорхойлогдоно гэж үздэг. Энэ нь урт болон богино хугацаанд ялгаатай. Богино хугацаанд эдийн засгийн идэвхжил потенциал түвшнээсээ хэр өндөр эсвэл бага байхаас үнэ өсөх дарамт ихээхэн шалтгаалдаг. Иймд мөнгөний бодлогоор үйлдвэрлэлийн зөрүүг зохистой түвшинд байлгах нь инфляцийн дарамтгүй эдийн засгийн өсөлтийн суурь болох юм. Мөнгөний бодлогоор аль нэг бараа бүтээгдэхүүний үнийг онилох аргагүй, энэ нь зохистой бодлого биш болох нь эндээс ойлгогдоно. Харин урт хугацаанд бол үйлдвэрлэлийн зөрүү тэг, хүү ханш гээд мөнгөний бодлогын чухал сувгуудыг төв банк шууд удирддаггүй. Иймд хүлээлт инфляцийн түвшинг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Урт болон богино хугацааны аль алинд хүлээлтийг удирдах гол

хэрэгсэл нь төв банкны олон нийттэй харилцаа учраас Монголбанк нээлттэй, ил тодоор хэрэгжүүлж байгаа бодлогоо зах зээлд оролцогчдод тайлбарлахад ихээхэн анхаарч байна. Түүнчлэн үүнд шаардлагатай санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг түгээхэд чармайлт гарган ажиллаж байна.

-Нийлүүлэлтийн гаралтай инфляциас гадна эдийн засгийн бүтцээс хамаараад манайд суурь инфляци ч харьцангуй өндөр бөгөөд савлагаатай явж ирсэн. Монголбанкны Ерөнхийлөгчөөр ажиллах энэ хугацаанд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын онцлог юу байв?

Эдийн засагт эрэлт эсвэл нийлүүлэлтийн гаралтай шок тогтмол үүсч байдаг. Үүнээс шалтгаалж инфляци дээш доош хэлбэлзлээ ч эрэлтийг удирдах замаар Төв банкны зорилтот түвшинд тогтворжуулах нь мөнгөний бодлогын гол зорилт юм.

2016 оноос хойш Монголбанкны Ерөнхийлөгчөөр ажиллахдаа хэрэгжүүлсэн мөнгөний бодлогыг дараах 3 үе шатанд хувааж болно. Эхний ээлжинд эдийн засагт өндөр эрсдэл хуримтлагдаад байсан 2016 оны сүүл - 2017 онд Монголбанк тогтворжуулалтын бодлого хэрэгжүүлж, уналтаас сэргийлэхэд анхаарлаа төвлөрүүлэн Засгийн газар болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байв. Энэ зорилт үр дүнтэй болсноор Монгол улс дефолттой нүүр тулах эрсдэлээс зайлсхийн, валютын нөөц нэмэгдэж, зээлжих зэрэглэл дээшилж, эдийн засгийн агшилтаас өсөлтийн замд орсноор инфляци эргээд төв банкны зорилтот түвшинд тогтворжсон. Эдийн засаг тогтворжсоны дараа мөнгөний бодлогоор бодит эдийн засгийг дэмжих нь чухал байв. Иймд инфляцийн зорилттой нийцтэйгээр мөнгөний бодлогыг зөөлрүүлэх шат дараатай алхмууд 2017, 2018 онд хийгдсэн. Үр дүнд нь эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, 2014-16 оны хүндрэлийн үед 12 улирал дараалан агшаад байсан өрхийн бодит орлого өсөлттэй болсон байна (Зураг 2).



Зураг 2. Үнийн түвшний өсөлт болон эдийн засгийн өсөлт, өрхийн бодит орлогын өсөлтийн харилцан уялдаа

Мөн банкны салбараас эдийн засагт нийлүүлэгдэх санхүүжилт нэмэгдэж, зээлийн хүү сүүлийн 8 жилийн доод түвшинд хүрч буурчээ. Харин 2018 оноос эдийн засгийн өсөлт эрчимжиж байсан ч гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдсэн тул цаашдын тогтвортой байдлыг хадгалах, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх нь чухал байлаа. Энэ үед макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлснээр хэрэглээний зээлийн хэт хурдтай өсөлтийг зохистой түвшинд хадгалах, банкны балансын долларжилтыг зохистой түвшинд байлгах, банкуудын бизнесийн зээл олгох инсентивийг нэмэгдүүлж дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг хэрэгжүүллээ. Өрхийн өрийн дарамтыг хэт нэмэгдүүлэхгүй байх, бизнесийн хөрөнгө оруулалтыг тогтвортой хадгалах нь цаашдын санхүүгийн тогтвортой байдал болон эдийн засгийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой юм.

-АНУ, Хятадын худалдааны зөрчилдөөн дэлхийн эдийн засагт сорилт болж байна. Гадаад орчны эрсдэл нэмэгдэж байгаа энэ үед эдийн засгийн төлөвийг хэрхэн харж, мөнгөний ямар бодлогыг хэрэгжүүлж байна вэ?

2019 оны хувьд дотоодын эдийн засгийн идэвхжил сайн, зуншлага цаг агаарын хувьд ч таатай, хэдийгээр дэлхийн эдийн засагт эрсдэл нэмэгдэн өсөлт саарч байгаа боловч нүүрс, зэс, алт, ноолуур гээд голлох экспортууд харьцангуй боломжийн түвшинд хадгалагдлаа. Өрхийн бодит орлого үргэлжлэн өсч, төлбөрийн тэнцлийн

орох урсгалууд хэвийн, татварын орлогын өсөлтийг дагаад төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардал аль аль нь нэмэгдсэн, бизнесийн зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр эдийн засаг тэлэлттэй явна. Иймд хэдийгээр гадаад орчны эрсдэлтэй уялдуулаад бид сүүлийн төсөөллөө бууруулсан ч 2019 оны өсөлт өнгөрсөн жилтэй ойролцоо түвшинд буюу 6-7% орчим байх хүлээлттэй. Ирэх 2020 оны хувьд өсөлт 5-6% орчим байх төсөөлөлтэй байна. Суурь инфляци тогтвортой байгаа тул дунд хугацаанд инфляци зорилтот түвшинд хадгалагдана гэж үзэж байгаа.

Цаашид гадаад орчны таагүй байдал нь экспортын үнэ болон хэмжээ, валютын орох урсгалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий. Иймд Монголбанк мөнгөний бодлогын зорилтоо эдийн засгийн өсөлтийг улам бүр нэмэгдүүлэх бус харин тогтворжуулах, инфляцийн дарамтгүй өсөлтийг удаан хугацаанд тэнцвэртэй хадгалах горимд шилжүүлээд байна. Гадаад орчны тодорхой бус байдал өндөр үед дотоод эрэлтийг хүчтэй тэлэх нь үнэ болон ханшид дарамт учруулахаас гадна санхүүгийн салбарт эрсдэл хуримтлуулж болзошгүй. Эдийн засаг үргэлж өсөлттэй байхгүй, уналтын цикл хэзээ нэгэн цагт ирнэ. Иймд хожим нь чанга унахгүйн тулд алсын хараатай байж, эдийн засагт одоо шаардлагатай зарим тохиргоог цаг алдалгүй хийх нь зүйтэй юм. Зүйрлэж хэлбэл бартаатай замд хурдаа тохируулж байна гэсэн үг. Монгол улсад түр зуурын өндөр өсөлт бус, дунд урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдал илүү хэрэгтэй.

Мөнгөний бодлогын хувьд цаашид гадаад эрсдэл нэмэгдэж, эдийн засгийн идэвхжилийг санхүүжүүлж буй гол мөнгөн урсгалууд татарсан тохиолдолд хүүн дээр ч, нөөц дээр ч орон зайгаа хадгалж үлдэхийг чухалчилж байна. Түүнчлэн санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, банкны салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн шинэчлэл, реформ үргэлжилнэ. Банкны салбар бизнесийн идэвхжилийг санхүүжүүлэгч гол суваг, мөн өмнө хэлсэнчлэн мөнгөний бодлогын үр дүнтэй байдалд чухал үүрэгтэй тул үйл ажиллагаа нь эрүүл, найдвартай байх нь маш чухал юм.

–Эдийн засаг сэргэж, валютын нөөц 4 дахин нэмэгдсэн ч төгрөгтэй харьцах ам.долларын ханш яагаад буурахгүй байна вэ?

Эдийн засгийн сэргэлтийг дагаад валютын эрэлт ч нэмэгддэг. Эдийн засаг өсөхөд өрхүүдийн хэрэглээ хурдтай тэлэхээс гадна, компани аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа өргөжүүлснээр гаднаас авах бизнесийн үйлчилгээ болон тоног төхөөрөмж нэмэгддэг. Мөн Монголд хөрөнгө оруулсан компаниудын ашигт ажиллагаа сайжирснаар ногдол ашгийн хуваарилалт нэмэгдсэн байна. Валютын гарах урсгал ийнхүү нэмэгдэж байгааг хэрэглээ болон хөрөнгө оруулалтын бараа бүтээгдэхүүний импортын өсөлт, гадагш аяллаар явж буй иргэдийн тоо, Монгол улсаас гарч байгаа тээврийн үйлчилгээний зардал, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын ногдол ашиг зэрэг үзүүлэлт харуулна. Мөн Монгол улсын гадаад өрийн хэмжээ өндөр байгаа тул улсын болон хувийн хэвшлийн өрийн үйлчилгээний зардал валютын гарах урсгал дээр багагүй ачааллыг үүсгэх болсон. Иймд хэдийгээр экспорт түүхэн дээд түвшинд хүрч өссөн, ГШХО-ын орох валютын урсгал сайн, хувийн хэвшил олон улсын зах зээлээс татдаг санхүүжилтүүд хэвийн байсан боловч төлбөрийн нийт тэнцэл дээрх дарамт багагүй байсаар байна. Ханшийн хувьд валютын орох, гарах урсгалтай нийцтэй тогтох нь зохистой. Монголбанк огцом савлагааг үүсгэхгүйн тулд валютын захад шаардлагатай тохиолдолд оролцож ажилладаг. Энэ нь импортын барааны үнээр дамжаад инфляцид нөлөөтэйгөөс гадна банкны салбарын гадаад валютын зээлийн чанар, гадаад өрийн тогтвортой байдлаар дамжаад санхүүгийн тогтвортой байдалд чухал. Валютын нөөцийн хувьд цаашид учирч болзошгүй эрсдэлд бэлэн байх, зах зээлд оролцогчдын итгэлийг хадгалахад онцгой үүрэгтэй. Иймд алт тушаалтыг нэмэгдүүлэх, экспортлогч компаниудтай

хамтран ажиллах тал дээр Монголбанк идэвхтэй ажиллаж байна.

Дунд урт хугацаанд эдийн засагт тулгарах гол сорилт ба шийдлийг хэрхэн дүгнэж байна вэ? Төв банкны үүрэг роль ямар байх вэ?

Уул уурхайн салбараас хэт хараат эдийн засгийн эмзэг бүтцийг засах, ажиллах хүчний боловсрол бүтээмжийг дээшлүүлэх, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, байгаль цаг уурын өөрчлөлтөд бэлэн байх гэх мэт урт хугацааны чухал чухал асуудалд шийдэл олох нь бүх цаг үеийн бодлого тодорхойлогчдод сорилт болсоор ирсэн. Гэтэл түүхий эдийн үнийн хэлбэлзэл, хөрөнгийн дотогшлох урсгал дээрх эрсдэлүүд, гадаад өрийн эргэн төлөлт зэрэг сорилтууд хүлээгдэж байгаа нь урт хугацааны дээрх чухал асуудалд хангалттай анхаарал төвлөрүүлж, шийдэл хайх боломжийг хязгаарлаж болзошгүй. Иймд УИХ-д өргөн бариад байгаа 2020 онд хэрэгжүүлэх мөнгөний бодлогын баримт бичгийн төсөлд дунд хугацааны асуудлуудад шийдлийн эхний алхмууд, авах арга хэмжээг тусгаснаараа онцлог болж байна. Төв банк дангаараа шийдэх аргагүй сорилтуудад хамтын ажиллагаа чухал үүрэгтэй учраас бодлого тодорхойлогч бусад байгууллагууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай ажлууд багтсан. Тухайлбал эдийн засгийн тогтвортой өсөлтийг дунд хугацаанд хадгалах, гадаад өр төлбөрийг шийдвэрлэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх, мөнгө угаалт болон терроризмын санхүүжилттэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлийн ажлуудыг онцолж болно. Монголбанк мэдээж хуулиар ногдсон үүргийн хүрээнд инфляцийн дарамтгүй тогтвортой өсөлтийг хангах мөнгөний зохистой бодлого хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн реформоо үргэлжлүүлнэ. Сорилтууд айсуу цагт цаашид макро бодлогуудын хувьд сахилга бат, тууштай байдал, бодлогын уялдаа чухлаар тавигдах бол компани аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүгээ оновчтой төлөвлөх, иргэдийн хувьд санхүүгийн хуримтлал маш чухал юм. Товчхондоо ирэх жилүүдэд Монгол улс болзошгүй эрсдэлийг давах дархлаатай байж, эдийн засгаа тогтвортой байлгахын тулд улс орон, компани аж ахуйн нэгж, айл өрхөөрөө бэлтгэлтэй, алсын хараатай байх шаардлага тулгарч байна.

Танд баярлалаа!



“ТМБҮЧ-2020” ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийн тэмдэглэлээс хүргэж байна.

**СААРАЛ ЖАГСААЛТАД ОРСОНТОЙ
ХОЛБООТОЙГООР ТӨРӨӨС МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ (ТМБҮЧ)-Д ТӨСӨӨЛСӨН МАКРО
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ТОМООХОН
ӨӨРЧЛӨЛТ ОРОХ УУ? СААРАЛ ЖАГСААЛТЫН
ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ ЮУ БАЙХ ВЭ?**

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН**

ФАТФ-ыг дэлхийн 7 том байгууллага санаачилж, байгуулсан. Эгнээндээ 31 улсын гишүүнчлэлтэй. Монгол Улс ФАТФ-ын гишүүн болох Ази, Номхон далайн бүлгийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага (APG)-ын гишүүн. Тэгэхээр бид

APG-аар дамжаад ФАТФ-ын хяналтанд очиж байгаа. Монгол Улс анх Ази, Номхон далайн бүлгийн гишүүнээр 2004 онд элссэн. 2004 оноос хойш хамтын ажиллагаа, харилцан үнэлгээгээ хийгээд явж байсан. Монгол Улсын түүхэнд саарал жагсаалтад орсон үе гэж бий. 2013 оны аравдугаар сард ороод, 2014 онд нь гарч байсан. ФАТФ анх байгуулагдахдаа зөвхөн зөвлөмжүүд өгдөг байсан бол дараа нь тэр зөвлөмжөө хэрхэн хэрэгжүүлж байгааг нь шалгадаг болсон. ФАТФ-ын өөрийнх нь гаргасан 40 зөвлөмж бий. Үүнийг техникийн зөвлөмж гэдэг. Техник гэдэг маань хууль байна уу, хуулийг хэрэгжүүлэх байгууллага, институци нь байна уу гэх зэргийг хардаг. Юмтай зүйрлэвэл үзэгтэй адил. Өөрөөр хэлбэл, сурагч үзэгтэй байх ёстой. Харин үзэг гарч байна уу, үгүй юу,

гаргаж чадаж байна уу гэдэг нь сурагчаас хамаарна. Яг үүнтэй адилаар 40 зөвлөмжөө хэрхэн биелүүлж, хэрэгжүүлж байна вэ гэдэг нь шууд хэрэгжилтийн 11 зөвлөмж юм.

Монгол Улсыг өнөөдөр хяналтандаа авахад үндэслэсэн үнэлгээ маань хэзээ гарсан бэ гэхээр 2013-2016 онд гаргасан шийдвэр, тухайн шийдвэрээ хэрэгжүүлсэн байдал, хууль эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн, хуулиа хэрэгжүүлж байгаа байдалд хийсэн үнэлгээнд үндэслэсэн. Бүр тодруулбал, APG-аас энэ үнэлгээг хийх 9 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж ажиллаад, 2017 оны тавдугаар сард харилцан үнэлгээний тайлангаа гаргасан байдаг. Тэгэхээр Монгол Улс энэ хяналтад албан ёсоор 2017 онд орсон. 2017 оноос хойш энэ хяналтаас гарах хугацааг Монгол Улсад олгосон. Өнөөдрийн байдлаар бид ФАТФ-ын 40 зөвлөмжийн 35-ыг нь дийлэнх болон бүтэн гэсэн байдлаар хангаж байгаа. Үлдсэн 5 дээр нь хагас хэрэгжилттэй гэсэн үнэлгээтэй байна. Гэхдээ энэ бол техникийн гэдэг утгаараа тодорхой хуулийн заалтад ороод ирэхэд л хангагдах боломжтой. Хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн хувьд 2017 оны байдлаар 9-ийг нь огт хангадаггүй, 2 дээр нь хагас дутуу хэрэгжилттэй буюу үндсэндээ 11-үүлээ хэрэгжилтгүй байсан. Тэгвэл хамгийн сүүлд Бангкок болсон хурлаар 11 үзүүлэлтээс 7-г нь хангасан, үлдсэн 4 дээр нь нэмэлт ажлууд хийх хэрэгтэй байна гэж үзсэн. Ингээд ФАТФ-ын Парист болсон хурлаар Монгол Улс хяналтанд орсон хэвээр байна, дахиад энэ 4 ажлыг хэрэгжүүлэх үүрэг авсан гэдгийг мэдэгдсэн.

Тэгэхээр Монгол Улсын хувьд хийх ажил нь тодорхой байгаа. Үүний дагуу Хамтын ажиллагааны зөвлөл дээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан.

Төлбөр тооцоо хийгдэхээ болино, олон улсын картууд ажиллахаа болино, Монгол Улс руу мөнгө урсахаа болино гэдэг ч юм уу, янз бүрээр л тайлбарлаад байна. Энэ бол хоосон хийрхэл маягийн, сандралд орсонтой холбоотойгоор гарч байгаа зүйл.

Монголбанк мэдэгдэл гаргасан. Мэдэгдэлд “Энэ хяналт 2017 оноос эхэлсэн. Өнөөдөр гэнэт гарч байгаа шийдвэр биш. Тийм учраас сандрах зүйлгүй” гэдгийг дурдсан. ФАТФ-ын мэдэгдэл дээр давхар бас нэгэн мэдээлэл бий. Тэр нь хяналтанд орж байгаа улсуудтай ФАТФ-ын гишүүн улсууд харилцаагаа хэвийн үргэлжлүүлээрэй, ямар нэгэн хориг, саад тавихыг шаардахгүй гэдгийг дурдсан байна. Тэгэхээр Монгол

Улсын эсрэг ямар нэгэн хориг саад гарч ирэхгүй байх. Яагаад гэвэл ФАТФ өөрөө гишүүддээ зөвлөмж маягаар хүргүүлсэн байна шүү дээ.

Нөгөөтэйгүүр яагаад 2017 оноос хойш энэ хяналт эхэлсэн гэдгийг дурдаад байна вэ гэхээр тухайн онд энэ хяналтанд орсонтой холбоотойгоор банкууд нэлээд олон улс дахь харилцах дансаа хаасан. Тэгэхээр эрсдэлийн шок аль 2017 оноос хойш эхэлсэн. Одоо нэмж шок ирэхгүй. Өнөөдрийг хүртэл бидэнтэй харилцаж байгаа банкууд бол энэ эрсдэлийг мэдээд, харилцаж байгаа банкууд. Тэгэхээр бид өөрөө өөрсдийгөө стресстүүлээд, сандралдах хэрэггүй л гэж зөвлөх байна.

Хоёрдугаарт, ханштай холбогдуулаад хэлэхэд, өнөөдөр Монгол Улсын эдийн засаг 6.5 хувиар өсч байна. Тэгэхээр эдийн засгийн өсөлт өндөр хэвээр байна. Төсөв энэ онд алдагдалгүй гарна. Мөн гадаад худалдааны тэнцэл бараг тэрбум ам.долларын ашигтай явж байгаа. Төлбөрийн тэнцэл мөн ашигтай гарсан. Эдгээр дунд манай валютын нөөц өсч байгаа. Өнөөдөр 4 тэрбум ам.долларт хүрээд байна. Эдийн засгийн суурь нь сайн байхад яагаад төгрөгийн ханш унана гэж сандраад байгаа нь ойлгомжгүй байна. Тийм учраас Монголбанк юу гэж хэлж байна вэ гэхээр ханш дээр онцлогтой шок ирэхгүй, эдийн засгийн сууриараа тийм нөхцөл үүсэх шалтгаан байхгүй.

Яагаад гэвэл рейтинг хийж байгаа гадны гурван байгууллага 2017 оноос хойш манай зээлжих зэрэглэлийг өсгөж ирсэн. Саарал жагсаалтад орсныг мэдсэн мөртлөө нэмэгдүүлж байсан. Нөгөөтэйгүүр бид бас судалж үзсэн. “Саарал жагсаалт”-д орсон улсуудын хувьд ямар хүндрэл гарч байсан, юу болж байсан гээд. Тэгэхээр саарал жагсаалтад орсон улсуудын зээлжих зэрэглэл буурсан тохиолдол бараг байхгүй юм билээ. Монгол Улсын хувьд хяналтанд орлоо гээд зэрэглэл буурна гэж харахгүй байгаа.

СААРАЛ ЖАГСААЛТАД ОРСОНТОЙ ХОЛБООТОЙГООР МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТООЦООЛЛУУДАД ТОДОРХОЙ ӨӨРЧЛӨЛТ ОРОХ УУ?

МБГ-ын захирал **Б.БАЯРДАВАА:**

Саарал жагсаалтын эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх байдлыг ерөнхийд нь дүгнээд үзвэл эдийн засгийн өсөлт 5.1-6.3 хувьтай гарахаар байна. Үүний голч нь 5.6 хувь гэж тооцвол хамгийн муугаар тооцоолж үзсэн ч эдийн засгийн өсөлт дээрх голчоос дордохгүй. Хоёрдугаарт,

саарал жагсаалт юугаар дамжиж эдийн засагт нөлөөлөх вэ гэхээр нэгдүгээрт, зээлжих зэрэглэлийн бууралт байж болно. Гэхдээ бусад улс орнуудыг харвал зээлжих зэрэглэл буурсан тохиолдол ховор. Зарим нэг буурсан улс орнуудад энэ нь чухам юунаас болсон бэ гэдэг нь тодорхой харагддаггүй. Өөрөөр хэлбэл, зээлжих зэрэглэл буурахдаа саарал жагсаалтаас болсон уу, эсвэл тухайн улсын төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалав уу гэдэг нь тодорхой харагддаггүй. Саарал жагсаалт ямар тохиолдолд хүндрэл учруулдаг вэ гэхээр тухайн улс орон өөрөө төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй байгаа үед сөргөөр нөлөөлдөг. Өнөөдөр Монгол Улсын төлбөрийн тэнцлийг харвал экспортын орлого сайн, импортын өсөлт бага буюу өнгөрсөн оны мөн үеэс дөнгөж 9 хувийн өсөлттэй байна. Тэр дотроо бараг ганцхан бүтээгдэхүүний импорт ихэнхийг нь тайлбарлаж байх жишээтэй. Нэг ёсондоо балансжсан. Нөгөө талаар гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээл, санхүүжилтийн урсгал гайгүй байна. Ийм тохиолдолд Монгол Улсын хувьд төлбөрийн тэнцлийн хүндрэл байна гэж үзэх үндэсгүй. Тэгэхээр тэр талын нөлөөлөл гарахгүй.

Нөгөөтэйгүүр бид яагаад саарал жагсаалт манай улсын эдийн засагт сөрөг нөлөө багатай гэж харж байна вэ гэхээр хяналтад орсон улс орнуудтай хийж байгаа төлбөр тооцоо, гүйлгээг л сайн нягталж, шалгах ёстой болдог. Харин саарал жагсаалтаас богино хугацаанд эргээд гарвал сөрөг үр дагавар нь эдийн засагтаа орж ирэхгүй юм. Энэ утгаар нь харвал хөрөнгө оруулалт, экспорт, импортын харилцаанд том нөлөө үзүүлэхгүй.

Харин цаашид бидэнд юу чухал вэ гэхээр дөрвөн чиглэлийн хэрэгжүүлэх ёстой ажлаа л аль болох хурдан хийх. Нэгэнт анхааруулах дохиог олон улс бидэнд өгсөн. Тийм учраас бид үүнийг хийх л ёстой. Тэгж байж, бид дэлхийн санхүүгийн харилцаанд орж явна.

Монголбанкны ЭЗССХ-ийн захирал **С.ДЭМБЭРЭЛ**

Эдийн засагчийн хувьд, мөн тодорхой хэмжээгээр улс төр сонирхдог хүний хувьд өөрийнхөө бодлыг хэлье. Саарал жагсаалтад орох асуудал манай улсын засаглалтай их хамааралтай юм болов уу гэсэн сэтгэгдэл төрсөн. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын засаглалын болон институцийн чанарын сул байдлыг харуулж байгаа. Мөдхөн буруутныг хайх үйл ажиллагаа явагдана. Надад төрсөн сэтгэгдэл бол манайхан ер нь ажил хийж чаддаггүй юм байна. Ямар утгаараа

гэхээр асуудлыг цаг хугацаанд нь шийдэх асуудал. Ялангуяа шүүх дээр мөнгө угаахтай холбоотой хэргүүд шийдэгддэггүй. Прокурор дээр очоод гацчихдаг. Эрүүгийн хуулинд мөнгө угаах гэсэн заалт байдаг мөртлөө нөгөө талаас төрийн өмчийг шамшигдуулах гэсэн заалт ч бий. Хэзээ ч энэ улсад мөнгө угаах зүйлчлэлээр ял авсан хүн байхгүй. Гэтэл мөнгө угаах гэдэг чинь юу вэ гэхээр хууль бус мөнгө олохыг л хэлнэ. Хууль бусаар мөнгө олж байгаа хэрэг зөндөө гараад байхад, яагаад тэр хэргүүд нь мөнгө угаахаар шийтгэгддэггүй юм бол. Хоёрдугаарт, миний бас нэг гайхаж байгаа зүйл юу гэхээр Монголбанк яагаад өөр дээрээ бүх дайралтыг аваад байгаа юм. Миний ойлгож байгаагаар мөнгө угаахтай тэмцэх үндэсний зөвлөл гэж бий. Тэр зөвлөлийн нэг хэсэг нь л Монголбанк. Тэгэхээр энэ бол Монгол улсын хэмжээний асуудал.

ҮЕ ҮЕИЙН СОНГУУЛИАР ТӨРИЙН ҮРГҮЙ ЗАРДАЛ НЭМЭГДДЭГ. 2020 ОНЫ СОНГУУЛИАР ЭНЭ БАЙДАЛ ГАРНА. ҮҮНИЙ НӨЛӨӨ МӨНГӨНИЙ БОДЛОГОД ХЭР НӨЛӨӨЛӨХ ТААМАГ БАЙНА ВЭ? ТӨСВИЙН ЗАРДАЛ ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА УУ?

Ерөнхий эдийн засагч **Д.ГАН-ОЧИР**

ОУВС-ийн Монголын эдийн засаг, нийгмийн байдал, засаглалын байдалд үнэлгээ хийсэн тайланд дурдагдсан хамгийн том эрсдэл нь улс төрийн эрсдэл. Үүнийг хоёр утгаар тайлбарлаж байгаа. Эхнийх нь сонгууль утгасан хэт тэлсэн мөнгөний болон төсвийн бодлого хэрэгжүүлж болзошгүй байдаг. Хоёрдугаарт, дараагийн Засгийн газар гарч ирээд, өмнөх Засгийн газраасаа тэс өөр макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлж болзошгүй байдаг юм. Асуулт бол энэ хүрээнд төсвийн зардал хэт тэлэхтэй холбогдож байна. Ерөнхийдөө төсвийн зардал хэт тэлж байна уу гэдгийг авч үзье. Эдийн засгийн өсөлтийг 2020 онд Засгийн газар 6 хувьтай байхаар, Монголбанк дунджаар 5.5-6 хувь байхаар тооцож байгаа. Тэгэхээр эдийн засгийн өсөлт 6 орчим хувьтай, инфляци 8 орчим хувьтай буюу нэрлэсэн ДНБ-ий өсөлт 14 орчим хувьтай байх нь. Харин төсвийн зардлыг 20 хувь байна гээд тусгасан. Энэ өнцгөөр харвал төсвийн зардал нэлээд тэлэлттэй байна гэж харагдаж байгаа. Гэхдээ бид макро эдийн засгийн тооцоолол, загварт оруулахдаа төсвийн зардал хэт тэлэлттэй байна уу, эсвэл агшилттай байна уу гэдгийг тооцоолохдоо "Төсвийн импульс" гэдэг зүйлээр хэмждэг. Энэ нь өнгөрсөн оны төсвийн алдагдал ДНБ-

ий хэдэн хувь байсан, өнөөдөр хэдэн хувь байна вэ гэдгийг харьцуулдаг. Гэтэл өнгөрсөн онд батлагдсан төсвийн алдагдал ДНБ-ий 5.4 хувь байсан. Одоо өргөн баригдсан байгаа нь 5.1 хувь. Тэгэхээр алдагдлыг энэ хэмжээнд нь батална гэж үзвэл, том зургаараа төсвийн бодлого хэт тэлэлттэй гэж харагдахааргүй байгаа юм.

Гэхдээ Монголбанк өөрөө Засгийн газраас гадна төсвийн орлогын тооцооллуудыг хийдэг. Тэгэхэд 700 орчим тэрбум төгрөгийн зөрүү орлого тал дээр гарч байгаа. Тэгэхээр зардал маань өргөн барьснаараа батлагдсан ч гэсэн орлого маань 700 орчим тэрбум төгрөгөөр дутвал төсвийн алдагдал өсөх эрсдэл байна гэж харж байгаа. 700 тэрбум төгрөг нь төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг 1.7 пунктээр өсгөж байгаа. Өнөөдөр төсвийн алдагдлыг ДНБ-ий 5.1 хувь гээд өргөн барьсан нь бодит байдал дээр 6.8 хувь болж өсөх эрсдэл байна.

Хоёрдугаарт, гол асуултад хариулахад төсвийн зардлын бүтэц бүх төрлөөрөө тус бүрдээ 19-21 хувиар өсөхөөр оруулж ирсэн. Төсвийн байгууллагын цалингийн өсөлт, тэтгэвэр тэтгэмжийн өсөлтийг дэмжиж байгаа. Төрийн албан хаагчдын цалинг 8 хувиар өсгөнө, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажилласан жилийн нэмэгдлийг шинээр олгоно гээд, нийтдээ 300 гаруй тэрбум төгрөг тусгасан байгаа. Цалингийн өсөлтийг яагаад хүлээн зөвшөөрч байна вэ гэхээр өрхийн өрийн дарамт гэдэг асуудал бий. Монголбанкнаас хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого хэрэгжүүлж байгаа. Энэ нь хязгаарлаж байгаа богино хугацааны зохицуулалтын бодлого болохоос биш үндсэн асуудлыг шийдэхгүй. Тэгэхээр өрийн дарамтыг багасгахын тулд нэг талаас орлого нэмэгдэх ёстой. Тэгж байж, илүү гарсан орлогоо хуримтлуулж, өрийн дарамтнаас гарах санхүүгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх учиртай. Тэгэхээр төрийн албан хаагчдын цалингийн өсөлт хувийн секторын цалингийн өсөлтөд нөлөөлөх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, өрийн дарамтыг шийдвэрлэхэд бага боловч дэмжлэг үзүүлнэ гэж харж байгаа. Бусад зардлын хувьд ерөнхийдөө төсвийн орон зай дотроо явбал, төсвийн бодлого макро эдийн засагт хэт их савлуулсан хүндрэл учруулахгүй.

МИНИЙ ОЙЛГОЖ БАЙГААГААР МОНГОЛБАНК ЖИЛ БҮР Л ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ БАГА БАЙЛГААЧ, БУУРУУЛААЧ, АЛДАГДАЛГҮЙ БАТЛААЧ ГЭДГИЙГ ЗӨӨЛӨН АРГААР ЗАСГИЙН ГАЗАРТ ЗӨВЛӨДӨГ. ЗАСГИЙН ГАЗАР ҮГЭНД ЧИНЬ ОРДОГГҮЙ. ИЙМ БАЙДАЛ ҮРГЭЛЖЛЭЭД ЯВАХ ЮМ УУ, ЯАХ ЮМ?

МБГ-ын захирал **Б.БАЯРДАВАА**

Бид өнгөрсөн хугацаанд төсвийн хүндрэлд орсон гол шалтгаан юу гэхээр орлогыг хэт өөдрөгөөр төсөөлөөд, тэрэндээ тааруулаад, алдагдлаа бага байна гэж өргөн барьдаг. Их хурал зардлыг нь нэмээд, бодит байдалтай нүүр тулангуут орлого нь дутагддаг. Орлого дутагдангуут тодотгол хийдэг. Тодотгол хийхдээ зардлаа биш орлого тодотгоод, алдагдлаа санхүүжүүлэх эх үүсвэрээ тодотгодог, ийм л циклтэй явж ирсэн. Үүнийг бид засах ёстой. Хоёрдугаарт, эдийн засагт эрсдэл хэзээ хуримтлагддаг вэ гэхээр эдийн засаг уналттай байгаа үед бус, харин өсөлттэй байгаа үед бий болдог. Ялангуяа гадаад сектороос өндөр хамааралтай эдийн засгийн хувьд энэ илүү тохиолддог. Нэг ёсондоо тэр эдийн засаг гадаад сектороос орж ирж байгаа нэмэлт орлогыг маш буруу, үрэлгэн байдлаар зарцуулдаг нь дараа, дараагийнхаа эрсдэлийг бий болгож байдаг. Үүнийг бид сануулж, засаж явах ёстой.

Түүнчлэн төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд анхаарах ёстой хэд хэдэн зүйл бий. Манай улс дэлхийд төсвийн маш сайн дүрэмтэй гэж үнэлэгддэг. Нэгдүгээрт, төсвийн орлогод том нөлөөтэй эрдэс бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийг тооцохдоо 18 жилийн үнийг хардаг. Өнгөрсөн 12, өнөөдрийнх, ирэх 5 жилийн төсөөлөлд үндэслэж, тэнцвэржүүлж тооцдог. Энэ нь ямар үр нөлөөтэй вэ гэхээр эдийн засгийн уналтын мөчлөг ирж байгаа үед хоёр орон зайгаар төсвийн орлогыг өөдрөгөөр тооцоолох боломжийг олгож байгаа. Нэгдүгээрт, ирээдүйн үнээ харьцангуй өөдрөгөөр төсөөлөх. Хоёрдугаарт, өнгөрсөн хугацаанд эрдэс бүтээгдэхүүний үнэ хэрвээ өндөр байсан бол 12 жилийн дундаж үнэ маш хөшүүн, удаан хөдөлж харагдаж байгаа. Тэгэхээр тэр тохиолдолд уг нь төсөв дээрээ хуримтлал үүсгэж байсан бол даваад гарах бололцоотой байдаг. Гэтэл Монголын эдийн засаг өнөөдөр төсвийн тогтворжуулалтын сан дээрээ хуримтлал үүсгэж чадаагүй байгаа. Тэгэхээр төсвийн тогтвортой байдлын тухай хууль маань уналтын болон

өсөлтийн цикл дээр хоёр өөр, ялгаатай нөлөө үзүүлж байна.

Хоёрдугаарт, төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд төсвийн зардал дээр хязгаарлалт хийх ямар ч зохицуулалт байхгүй. Тэр чиглэлийн зохицуулалт, параметруудийг бий болгох ёстой. Гуравдугаарт, төсвийн тогтвортой байлын зөвлөлийг байгуулсан. Энэ зөвлөлийн үйл ажиллагааг үнэхээр хүчтэй нөлөөтэй болгох ёстой. Зүгээр нэг зөвлөмж өгөх бус хүчтэй нөлөөтэй болгох нь чухал юм.

Монголбанкны Ерөнхий эдийн засагч **Д.ГАН-ОЧИР**

Мэдээж төсвийн сахилга бат чухал. Мөн төсвийн алдагдал бага байх нь чухал. Гэхдээ том зургаараа, эдийн засгийн ирээдүйн төлөвийг аваад үзвэл өнөөдрийн төсвийн алдагдал нь өрийн тогтвортой байдлыг алдагдуулах түвшинд байна уу, үгүй юу гэдэг нь чухал. Өнөөдрийн баталж байгаа ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэх төсвийн алдагдал нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг аваад үзвэл төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан ЗГ-ын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 40 хувьд хүрнэ гэсэн хандлагатай нийцтэй байгаа юм. Энэ оны төгсгөл гэхэд ДНБ-ий 49.9 хувьд хүргэнэ. Дараагийн хоёр жилд шат дараатай бууруулснаар 39.1 хувьд хүргэнэ гэж байгаа. Тэгэхээр энэ сахилга батаа хангаад явбал, төсвийн алдагдлыг хэт өндөр гэж харах эдийн засгийн агуулга харагдахгүй байгаа юм. Яагаад гэвэл төсвийн алдагдал өнгөрсөн онд 5.4 хувиар батлагдсан. Энэ онд үүнээс огцом хэтэрхий багасгаж батлах нь эргээд эдийн засаг дээр агшилт бий болгох нөхцөл байдлыг бий болгоно. Тэгэхээр 5.4, 5.1 хувь гэх зэргээр аажмаар бууруулж явах зарчмаа хадгалж явах нь чухал юм. Төсвийн алдагдлын бууралтыг цаашдаа хадгалж явах нь өрийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН**

Монголбанкны мөнгөний бодлого төсөвтэйгөө уялдахын тулд бид орон зайг л анхаарч, харж явдаг. Төсөв хэр их тэлж байна вэ, эдийн засаг руу хэр их мөнгө нийлүүлж байна вэ гэдгийг хараад, Монголбанкинд хэр хэмжээний орон зай үлдсэн байна вэ гэдэг асуудал. Төсөв алдагдал нь ДНБ-ий 5.1 хувь байхаар өргөн баригдлаа гэж байна. Гэтэл зардал нь 11 их наяд төгрөг. Энэ зардал жилээс жилд өсч л байгаа. 11 их наяд төгрөг төсвийн бодлогоор дамжиж Монгол Улсын эдийн засагт 2020 онд орвол мөнгөний бодлогоор

дамжиж хэр хэмжээний мөнгө нийлүүлэх вэ. Эдийн засаг, инфляци, ханшийн тогтвортой байдлаа хараад, Монголбанкинд хэр хэмжээний мөнгөний нийлүүлэлт хийх орон зай үлдэж байна вэ гээд харвал бараг орон зай байхгүй. Тийм учраас бид ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Валютын сангийн зөвлөхүүд юу гэж хэлдэг вэ гэхээр та нарт бараг орон зай байхгүй. Тийм учраас мөнгөний бодлого хатуу байх ёстой, бодлогын хүүгээ чангаруул гэдэг. Тэгэхээр төсөв тогтвортой, зохистой хэмжээнд өсч байж, мөнгөний бодлогод орон зай гарна.

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД МОНГОЛБАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА. ДЭЭРХ СИСТЕМИЙН ЭЗЭМШИГЧ НЬ ХЭН БАЙХ ВЭ? ЯАГААД? ТӨЛБӨР ТООЦООНЫ ШИНЭ СИСТЕМ НЭВТЭРСНЭЭР БАНКУУДЫН ТӨЛБӨР, ТООЦОО ХЭСЭГ СААТСАН. БАНКУУД МОНГОЛБАНКНЫ СЕРВЕР УНАСАН ГЭЖ ХАРИУЛСАН. ЭНЭ ЦААШИД ДАВТАГДАХГҮЙ ГЭХ БАТАЛГАА БАЙНА УУ?

ТТГ-ын хэлтсийн захирал **А.БАТСАЙХАН:**

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр төлбөрийн системийн шинэчлэл төслийг Монгол Улсад хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрч байна. Энэ төслийн нэг хэсэг нь дээр дурдсанчлан үнэт цаасны бүртгэлийн шинэ систем оруулж ирэх гэж байгаа. Энэ системийн үндсэн зорилго юу вэ гэхээр Төв банкнаас гаргаж байгаа үнэт цаасны үлдэгдэл болон арилжааны тооцооллыг хийх зорилготой юм. Тэгэхээр эзэмшил нь Монголбанкин дээр байна. Энэ төсөл өөрөө Монголбанкин дээр хэрэгжиж байгаа. Мөн хэрэгжүүлж байгаа газар нь Монголбанк, үндсэн зорилго нь бас Монголбанктай холбоотой учраас эзэмшил нь энд байна. Гэхдээ нэгэнт том систем оруулж ирж байгаа учраас үүнийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон арилжааны төлбөр тооцооны төв гэсэн хоёр байгууллага дээр цуг ашиглах боломжтой. Ингэвэл энэ хоёр байгууллага дээр систем нэвтрүүлэх зардлыг хэмнэж болно гэсэн санал бий. Гэхдээ эцсийн шийдвэр гараагүй байна. Үүний нөгөө талд энэ хоёр байгууллага дээр Төв банкны энэ системийг ашиглах боломжтой эсэх судалгаа хийгдэж байна. Хэрвээ нэвтрүүлж чадвал маш их хэмжээний зардал мөнгө хэмнэнэ.

Хоёр дахь асуултын тухайд АСН+ системийг нэвтрүүлсэн. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг шинэчилж, 8-р сарын 15-нд АСН+ системийг нэвтрүүлсэн. Үүний дараа нэг банкин дээр тодорхой хэмжээний доголдол үүссэн. Энэ банк хийгдсэн гүйлгээнүүдийг хүлээж авч чадахгүй, хүлээж авсан ч тухайн харилцагчийн дансанд бүртгэж авч чадахгүй, ийм нөхцөл байдал нэг өдөр орчим үргэлжилсэн. Бид шуурхай ажиллаад, тухайн банктай хамтарч тест хийгээд, алдаа дутагдлыг нь илрүүлж, зассан. Алдаа гарч байх үед тухайн банкны теллер болон лавлах утсан дээр “Монголбанкнаас шинэ систем нэвтрүүлснээс болоод ийм зүйл болсон” гэх агуулгатай, тодорхой хэмжээнд буруу тайлбар явсан. Үүн дээр Монголбанкны системд ямар нэгэн саатал, доголдол үүсээгүй гэдгийг энд хэлмээр байна. Бусад банкны гүйлгээ хэвийн явагдаж байсан. Энэ систем дээр Монголбанк өдөр тутам хяналт тавьж байгаа. Шинэ систем нэвтрээд, одоо жигдэрчихсэн. Дахиж ийм асуудал гарахгүй.

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН**

Тодруулж хэлэхэд, Азийн хөгжлийн банкаас “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлж байгаа. Хууль эрх зүйн орчны хувьд 2017 онд бид Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиа батлуулсан. 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс мөрдөөд эхэлчихсэн. Энэ системийн хүрээнд томоохон шинэчлэл хийгдэж байгаа. Төлбөр тооцоог аль ч улсад Төв банк зохицуулдаг. Төв банкны зохицуулалтаар явдаг томоохон дэд бүтэц юм. Төлбөрийн систем дотроо гурван том хэсэгт ангилагддаг. Нэгдүгээрт, том дүнтэй гүйлгээ буюу 3 сая төгрөгөөс дээш дүнтэй бүх гүйлгээ. Хоёрдугаарт, 3 сая төгрөг хүртэлх гүйлгээ буюу бага дүнтэй гүйлгээ. Дээр нь картын төлбөр тооцоо буюу карт хоорондын процессын үйл ажиллагаа бий. Монголбанкны хувьд их дүнтэй төлбөр тооцооны системээ шинэчилсэн. Энэ нь өөрөө ISO-20022 гэж стандарттай нийцэж байгаа. Сая ашиглалтад оруулсан АСН+ систем нь бас л дээр дурдсан ISO20022 стандартыг хангасан. Дэлхий даяараа энэ стандартад 2021 онд шилжих гэж байгаа. Монгол Улсын хувьд бусдаас түрүүлж, энэ стандартад шилжсэн. Дараагийнх нь картын свитчинг гэж бий. Бүх банк карт гаргаж байгаа. Картаа хийж байгаа бүхий л банк хоорондын төлбөр, тооцооны мэдээлэл Монголбанкны дээр ирж, нэгтгэгддэг. Энэ систем маань удахгүй шинэчлэгдэнэ. Энэ систем шинэчлэгдсэнээр бүх карт чиптэй болно. Тэгэхээр ямар нэгэн гэмт

хэргийн халдлагад өртөх боломжгүй, өндөр түвшний хамгаалалттай болох юм.

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТ БАНКНЫ БИЗНЕСИЙГ ХЯЗГААРЛАЖ, БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН БИЗНЕСИЙГ ДЭМЖСЭН ҮҮ. ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД УЯЛДАА, ХОЛБООТОЙ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙХ?

ХШГ-ын хэлтсийн захирал **Ё.МӨНХБАТ**

Мэдээж энэ шийдвэр хоёр талтай. Банкуудын бизнесийн загвараас хамаараад үйл ажиллагаанд нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байгаа. Монголбанкнаас яагаад ийм шийдвэр гаргасан талаар өмнө нь олон удаа тайлбарласан. Хэрэглээний зээл маш их хэмжээгээр нэмэгдсэн. Ингэснээр өрхүүд өрийн дарамтад орох болсон. Инфляцийн өсөлт, ханш, зээлийн өндөр хүүтэй холбоотойгоор энэ дарамт нэмэгдэх хандлагатай байсан. Тийм учраас Монголбанк хэрэглэгчдийг хамгаалах үүднээс, цаашилбал банкуудын үйл ажиллагааг тодорхой хэмжээнд тогтвортой байлгах үүднээс арга хэмжээ авсан.

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН**

2016 онд статистик харвал банкны сектороос нэг төгрөг ч шинээр зээл болж гарахаа больчихсон байсан. Эдийн засаг өөрөө зогсонги байдалд орсон байсан. Ингээд эдийн засгийг сэргээх хөтөлбөр хэрэгжсэн. Бүх зээл зогссон байсан учраас банкууд эргээд сэргээхдээ багаас нь гаргаж эхэлсэн. Ингээд 2017 онд гэхэд хэрэглээний зээл 70 хувиар өссөн статистик бий. Дараа жил нь 50 хувь, энэ жил 40 хувиар өссөн. Үүнээс гадна гаргаж байгаа зээлийнх нь бүтцийг аваад үзвэл 70 хувь нь хэрэглээний зээл, 30 хувь нь бизнесийн зээл болчихсон. Ерөнхийдөө шинээр гаргаж байгаа зээл маань хэрэглээнд түлхүү суурилчихсан, эдийн засгаа дэмжих, бодит сектор руу мөнгө бага гарч байсан. Монголбанк үүнийг харахдаа энэ бол эдийн засгийн буруу бүтэц рүү явж байна, тийм учраас ямар нэгэн хязгаарлалт, тоормос тавих хэрэгтэй гэж үзсэн. Тийм учраас макро зохистой бодлогын арга хэмжээ авч хэрэглэсэн. Ингээд хэрэглээний зээлүүдийг судалсан. Жишээ нь автомашины зээл дээд тал нь 8 жилд хүрчихсэн, тэтгэврийн зээл 60 сар гэх ч юм уу. Гэтэл бизнесийн зээл хэдхэн жилийн хугацаатай байна, яаж бизнес босч ирэх юм бэ гэх шүүмжлэл байдаг шүү дээ.

Тийм байхад машины зээл бараг 10 жил болчихоод, эсрэг чиглэлтэй яваад байсан. Тийм учраас бодлогын арга хэмжээ авсан. Хэрэглээний зээлийн хамгийн урт хугацаа 30 сар, өр орлогын харьцаа 60 хувь гэх зэрэг албадлагын арга хэмжээ авсан. Монголбанк зөвхөн банкнийг хянадаг. Банкнаас бусад салбарт манай арга хэмжээ очиж үйлчлэх хууль эрх зүйн боломж байхгүй. Тийм учраас бид санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах чиглэлд анхаарсан.

Бидний хувьд энэ зохицуулалт банкны болон банк бусын салбарт зэрэг хэрэгжээд явах ёстой гэж харж байгаа. Нөгөөтэйгүүр зээл болгон эргэж төлөгддөггүй гэдгийг статистик харуулж байгаа. Нийт зээлийн 10 хувь нь чанаргүйдсэн байна. Тийм учраас банк бус санхүүгийн байгууллагууд манай бизнес өргөжиж байна гээд энэ зээл рүү хэт их орвол эргээд чанарын үзүүлэлтэд нөлөөлөх эрсдэлтэй. Тэр эрсдэлийг банк бусын салбар дааж чадах уу гэдэг асуудал. Хэрвээ дааж чадахгүйгээр дампуурвал яах вэ. Хадгаламж зээлийн хоршоод 2000-аад оны эхээр бөөнөөрөө дампуурсан шиг асуудал гарвал яах вэ гэдэг асуудал бий. Энэ утгаараа санхүүгийн салбарт авч байгаа арга хэмжээ бүгдэд нь ижил үйлчлэх хэрэгтэй гэж Монголбанк үзэж байгаа. Тийм учраас хамтын ажиллагаагаа ойртуулах талаар нэлээд олон уулзалтуудыг хийж байгаа.

**БАНКНЫ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТООГ БУУРУУЛАХ, ШИНЭ
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТАЙ БОЛНО ГЭЖ ОЙЛГОЖ
БОЛОХ УУ? ХОЁРДУГААРТ, САНХҮҮГИЙН
ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ
БИЙ. ЭНЭ БОЛ УГ НЬ ЭДИЙН ЗАСАГЧДЫН**


**ЭСЭРГҮҮЦЭЭД БАЙДАГ ЗЭЭЛИЙН ХҮҮНИЙ ДЭЭД
ХЯЗГААРЫГ ТОГТООХ АСУУДЛЫН ХАРИУЛТ НЬ
ШҮҮ ДЭЭ. ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ, ЗЭЭЛИЙН ХҮҮНД
ХҮЧЭЭР ХЯЗГААР ТОГТООХ БУС САНХҮҮГИЙН
ХЭРЭГЛЭГЧЭЭ ХАМГААЛАХ ЗАМААР ЗЭЭЛИЙН
ЭРХ ТЭГШ ХАРИЛЦААНД ОРУУЛАХ АСУУДАЛ.
САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ
ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БАТЛУУЛАХ
ҮЙЛ ЯВЦ ЯМАР ШАТАНДАА ЯВЖ БАЙНА ВЭ?**

ХЭЗГ-ын захирал **Д.АЮУШ**


Банк санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бид нэлээд олон өөрчлөлтийг үе шаттайгаар хийж байгаа. Үүний хүрээнд хийгдэж байгаа нэг зүйл нь банкны засаглалыг сайжруулах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх асуудал. Бид энэ хүрээнд ТМБҮЧ-д юу тусгасан бэ гэхээр системийн нөлөө бүхий банкууд, банкны салбарын хувьцаа эзэмшигчдийн бүтцийн асуудлыг авч үзнэ. Олон улсын түвшинд ямар байдаг вэ, манайд нөхцөл байдал одоо ямар байна вэ, цаашид өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байна уу гэдэг судалгааг хийнэ. Хоёрдугаарт, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн зохицуулалт байна. Азийн хөгжлийн банктай хамтраад нэлээд олон судалгаа, тайлан гаргасан. Үүний үр дүнд шинээр хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн. Хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцээд, дэмжсэн. Одоо өргөн барихад бэлэн болсон байгаа. Энэ төсөлд санхүүгийн хэрэглэгч гэж хэн бэ гэдгийг “Өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зээл авч байгаа хүнийг хэлнэ” гэж томъёолсон. Мөнгө хүүлэлттэй холбоотой нэг бүлэг орж ирж байгаа юм.

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



- М2 мөнгөний жилийн өсөлт 14%-д хүрч 20.4 их наяд төгрөгт хүрэв.

- Өмнөх сараас 0.2%-иар буюу 42.8 тэрбум төгрөгөөр буурав.

Үүнээс М1 мөнгө 3.3% (130.7 тэрбум төгрөг)—иар буурч, бусад хадгаламж 0.5% (87.9 тэрбум төгрөг)—иар өссөн байна.


•М1 → төгрөгийн харилцах 66.3 тэрбум, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 64.4 тэрбум төгрөгөөр буурав.

•Бусад хадгаламж →төгрөгийн хадгаламж 69.5 тэрбум, гадаад валютын хадгаламж 19.3 тэрбум төгрөгөөр буурч, гадаад валютын харилцах 176.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Зураг 1.4. Нийт хадгаламж




- Нийт М2 мөнгөний нийлүүлэлтийн 52.8%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 15.7%-ийг төгрөгийн харилцах, 14.3%-ийг гадаад валютын хадгаламж, 14.3%-ийг гадаад валютын харилцах, үлдсэн 2.9%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 13.7 их наяд төгрөгт хүрснээс 85.1%-ийг иргэдийн хадгаламж, 14.9%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 21.5%-ийг, байгууллагын хадгаламжийн 20.3%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Нийт зээл, гадаад валютын эзлэх хувь



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 11.0%-иар өсч 18.0 тэрбум төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 14.6%-иар өсч 9.3 тэрбум,
- Хувийн байгууллагынх 7.0%-иар өсч 8.5 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн 12.6%-ийг, иргэдийн зээлийн 1.4%-ийг, хувийн байгууллагын зээлийн 24.6%-ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Зураг 2.3. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар




Зураг 2.4. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл **18.0 их наяд төгрөг** (**төгрөгийн** зээл **15.7** их наяд, **гадаад валютын** зээл **2.3** их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **0.6%-**иар
- Хэвийн зээл өмнөх сараас **1.1%-**иар тус тус буурсан.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **0.3%-**иар
- Чанаргүй зээл өмнөх сараас **3.1%-**иар тус тус өссөн байна.

3. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү




Зураг 4.2 . Нийт шинээр олгосон зээл, хүү



- Иргэдээс татсан Т-ийн хадгаламжийн ЖДХ **12.2%**, хувийн байгууллагаас татсан Т-ийн хадгаламжийн ЖДХ **11.3%** байна.
- Иргэдэд шинээр олгосон Т-ийн зээлийн ЖДХ **17.3%**, хувийн байгууллагад олгосон Т-ийн зээлийн ЖДХ **16.8%** байна.

4. Төлбөрийн тэнцэл

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 9 сар



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЭРХЭН НЭМЭГДҮҮЛЭХ ВЭ?



Монголбанк "Хөрөнгө оруулалтын орчин: Тогтвортой байдал" сэдэвт олон улсын бага хурлыг Олон улсын санхүүгийн корпораци болон Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулав. Дэлхийн худалдааны маргаан, эдийн засгийн удаашралаас үүдэлтэй экспортын голлох эрдэс бүтээгдэхүүний үнэ ирэх жилүүдэд буурах эрсдэл бий. Энэ нь 2020-2024 онд төлөгдөх 14.4 тэрбум ам.долларын гадаад өрийн төлбөртэй давхацсан тохиолдолд эдийн засгийг бүхэлд нь эрсдэлд оруулж болзошгүй талаар судлаачид энэ үеэр анхааруулж байлаа. Иймд эдийн засагт үүсч болзошгүй энэхүү сорилтод урьдаас бэлтгэлтэй байж, тогтвортой өсөлтөө хадгалахад анхаарах бодит шаардлага тулгараад байгаа тул гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр уг бага хурлаар хэлэлцсэн юм.

"Хөрөнгө оруулалтын орчин: Тогтвортой байдал" хэлэлцүүлгийн үеэр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх боломжийн талаар оролцогчид байр сууриа илэрхийллээ.





ЗГХЭГ-ын дарга,
Монгол Улсын
сайд
Л.ОУЮН-ЭРДЭНЭ



Монголбанкны
Ерөнхий эдийн
засагч
Д.ГАН-ОЧИР



Эдийн засагч
Н.ЭНХБАЯР

Монголд хөрөнгө оруулалт хийх сонирхол их байдаг. Үүнд дүгнэлт хийх ёстой. Гадны хөрөнгө оруулалт гэдэг бол шинжлэх ухаан юм. Ирээч гээд ирдэг зүйл биш. Ямар эрх зүйн орчин шаардлагатай вэ, ямар мэдээллийн орчин шаардлагатай вэ, гадаадын хөрөнгө оруулалтын аюулгүй байдлыг хангах асуудлыг хэрхэн цогцоор нь шийдэх үү, цаашлаад ямар хууль тогтоомж, дүрэм, журам гадаад орчинд ойлгогдохгүй байна вэ гэсэн олон зүйлүүдийг цогцоор нь харах ёстой.

Энэ утгаараа алсын хараа 2050 гэсэн бодлого хэрэгжиж байна. 30 жилийг бүхэлд нь дүгнэж, төсөөлөхийг хүсэж байгаа. Энэ нь өөрөө тогтвортой бодлогын суурь байх болов уу гэсэн бодолтой байна. Олон бодлого дэвшүүлдэг хэр нь хэрэгждэггүй, үйл ажиллагааны төлөвлөлт байхгүй, ямар нэгэн байдлаар санхүүгийн эх үүсвэрээ шийдвэрлэдэггүй, ерөнхийдөө тунхаг байдлаар орхиж явлаа.

Зөвхөн 1992 оноос хойш 517 бодлогын баримт бичгийг үйлдэж гаргасан байгаагаас энэ бүгдийг харж болно. Хэрэгжилт 30 орчим хувьтай байна гэдэг бол гадны хөрөнгө оруулалтын томоохон орон зай байхгүй болсон байна гэсэн үг. Нөгөө талаараа Монгол Улсын эдийн засаг хэт уул, уурхайгаас хамааралтай, дэлхийн зах зээлийн үнэ унахад манайх унадаг, өсөнгүүт дагаад өсдөг. Үүн дээрээс яаж эдийн засгийн төрөлжилт хийх вэ гэдгийг зайлшгүй хөндөх ёстой. Эдийн засгийн төрөлжилт гэдэг нь дахиад тунхаглал зарлаад орхих биш, татварын хөнгөлөлттэй бодлого, эдийн засгийн бүсчилсэн хөгжилтэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн орчин гээд олон зүйлийг цогцоор харах ёстой.

Урт хугацааны бодлого ярих гэж байгаа бол улстөржилтийг хаях ёстой болсон байна. Улс төрөөс илүү банк, санхүүгийн байгууллагын шинжээчид, эрдэмтийг сонсож явах зайлшгүй гарц руу орсон байна.

Монгол Улсын эдийн засгийн богино хугацааны хэлбэлзэл буюу халалт, уналтын 20 орчим хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт дангаар тайлбарлаж байна. Энэ утгаараа гадаадын шууд хөрөнгө оруулалтын огцом зогсолт бий болох нь эдийн засгийн уналт руу шууд хөтлөх сөрөг үр дагавартай. Тэр утгаараа гадаадын шууд хөрөнгө оруулалтын өөрийнх нь тогтвортой байдал, түүний тогтвортой орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн төрийн бодлогын асуудлууд гарцаагүй сонголт болоод байна. Хоёрдугаарт, гадаадын шууд хөрөнгө оруулалт нь богино, дунд хугацааны тогтвортой байдлаас гадна дунд, урт хугацааны хөгжлийн гол эх үүсвэр болж байна.

Дан ганц хөрөнгө мөнгө гэхээс илүү техник технологи, мэдлэг, засаглал гээд маш олон сувгуудаар эерэг нөлөөллийг үзүүлдэг. Нөгөө талаас зөвхөн дан ганц уул уурхайн салбарт орж ирж байгаа хөрөнгө оруулалт нь бусад салбарууд тэлэх дам эерэг нөлөөллийг бий болгож байгаа. Энэ нөлөөг илүү сайжруулахын тулд төрийн бодлого тэр тундаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх бодлого чухал юм.


Төрөлжүүлэхдээ уул, уурхайн салбарыг бусад салбартай харьцуулахад хөрөнгө оруулалтын дам нөлөөлөл харьцангуй сул байна. Илүүтэй үйлчилгээ, барилга, боловсруулах болон санхүүгийн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт нь бусад салбарын хөрөнгө оруулалтыг илүү далладаг, ажлын байр нэмэгдүүлдэг, нэг хүнд ногдох орлогод илүү нөлөөтэй байдаг гэсэн судалгааны үр дүн гарч байна. Төрөлжүүлэх бодлого нь дан ганц гадаад хөрөнгө оруулалт биш экспорт, эдийн засгийн төрөлжилтэд анхаарах гарцаагүй шаардлага байна.

ОУВС-гийн гишүүн 190 гаруй улс бий. 30-40 орон нь өндөр хөгжилтэй орон тул гаднаас хөрөнгө оруулалт төдийлэн авах шаардлагагүй улс. Бусад 150 улс нь хөрөнгө оруулалтын төлөө өрсөлдөнө. Хятад улсын жишээг олон нийтэд танилцуулж байсан. 2018 оны байдлаар гадаадаас авсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 135 тэрбум ам.доллар. Өөрөө бол асар их хөрөнгөтэй гадаад зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг улс. Гэтэл Хятад улс руу өндөр хөгжилтэй бусад улс орнуудаас тийм их хэмжээний хөрөнгө оруулалт орж байна. Дэлхийн зах зээл дээр хөрөнгө оруулалтын урсгал гэдэг бол нэгдүгээрт, маш их өрсөлдөөн. Хоёрдугаарт, маш тогтворгүй.

Бид нар хөрөнгө оруулалтын орчныг мөн тогтвортой байлгах хууль, эрх зүйн орчныг тогтвортой байлгахгүй бол мөнгөн ус шиг гэж ярьдаг хаашаа ч урсаад явчихаж болно. Үүнийг олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид сануулаад байдаг юм. Гэх мэт олон улсын хөрөнгө оруулагчдын хэлээд байгаа олон үзүүлэлтүүд дотроос нэг нарийн үзүүлэлтийг нь өдөр тутамдаа анхаарч сайжруулаад явах ёстой. Сайжруулах алхам нь тогтоол, шийдвэр гаргаад явах биш. Бүтцийн өөрчлөлтийн бодлого гэдэг том бодлогоор өөрчилж дунд хугацаанд алхам, алхмаар сайжруулж байж үр дүнг нь бид харна.

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2019/10/31-ний хооронд 1,708.4 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1277 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



АРАВДУГААР САРД 12.9 ТОНН АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2019 оны эхний 10 сард 12.9 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 17.8 тонн үнэт металл худалдан авснаас 4.9 тонноор бага буюу 27%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 10 дугаар сард 1.7 тонн үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 51.8 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 58.7 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 3.4 тонн үнэт металл худалдан авч байснаас 1.7 тонноор буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 10 дугаар сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 128,362.91 төгрөг байлаа.



График 1. 2018-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны сарын мэдээ (кг)



График 2. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)



График 3. 2019 оны 10 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг)



МОНГОЛБАНК

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШИНЭЧЛЭЛ АВЧ ИРСЭН ОН ЖИЛҮҮД

Монголбанкны Ерөнхийлөгч 2019.11.5-нд болсон Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр өөрийн бүрэн эрхийн 3 дахь жилийн хугацаанд хийсэн ажлаа үндсэн 4 агуулгад багтаан танилцуулсан юм. Энэ хугацаанд банкны салбарын хувьд томоохон шинэчлэлтүүд хийгдэж, макро эдийн засгийн түвшинд тогтворжилтийг бий болгосон түүний онцолсон 4 үйл ажиллагааны хүрээнд хийсэн бодлогуудын үр юм. Тэдгээрийг тоймлон тодруулбал.

Банкны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэв. Бодлого, үйл ажиллагааны өөрчлөлтийг эрхзүйн шинэчлэлгүйгээр хийх боломжгүй.

Банкны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчилж чадлаа. Эдийн засгийн ямар ч салбар ингэж хууль эрх зүйн өөрчлөлтийг хийж чадаагүй. Банкны салбар бол чадлаа. Үүнийг тэмдэглэж хэлэх ёстой.

Монголбанк 2016 оноос “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр 10 гаруй хуулийн төслийг боловсруулав. Үүнд:

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль,

- Банкны салбарын тогтвортой байдлын тухай хуулийг тус тус шинээр санаачлан УИХ-аар батлуулсан бол,
- Төв банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт,
- Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт,
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт,

- Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар батлуулав.

Үүний зэрэгцээ Активын удирдлагын тухай хуулийн төслийг шинээр боловсруулан, Валют зохицуулалтын тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хууль санаачлагч нарт уламжиллаа. Дараах хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагч нарт уламжлахаар ажиллаж байна. Үүнд:

- Векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,
- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай багц хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

Монголбанкнаас банк санхүүгийн салбарын харилцагчдын эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Монголбанк ийнхүү хууль эрх зүйн шинэчлэлийг хийх хүрээнд олон нийтийн эдийн засаг, санхүүгийн мэдлэгийг дэмжих зорилгоор Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа, Санхүүгийн боловсрол, Цахим эринд—Цахим төлбөр тооцоо, Хариуцлагатай харилцагч-Хариуцлагатай банк зэрэг аянуудыг орон даяар хэрэгжүүллээ.

Гадаад валютын албан нөөцийг 4 дахин нэмэгдүүлэв. Улс орны тусгаар тогтнолын санхүүгийн баталгаа бол гадаад валютын албан нөөц (ГВАН) юм. Иймд ГВАН-ийг нэмэгдүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж ирлээ.

2016 онд Монгол Улсын гадаад валютын нөөц 1 тэрбум ам.доллар байсан. Өнөөдөр 4 тэрбум ам.долларт хүрч, 4 дахин нэмэгдлээ.

Монголбанк 2016 онд 1 тэрбум ам.долларт хүрч огцом буураад байсан валютын нөөцийг 2019 оны 9-р сард буюу 3 жилийн дотор 4 дахин нэмэгдүүлж 4 тэрбум ам.долларт хүргэж чадлаа. 2016 оны эхний 3 улиралд гадаад валютын цэвэр нөөц Монголбанкны тодорхойлолтоор -402.5 сая ам.доллар, ОУВС-гийн тодорхойлолтоор -2.75 тэрбум ам.долларт хүрээд байсан бөгөөд төлөгдөх гадаад өр төлбөрүүд хүлээгдэж байсан тул эдийн засаг үндсэндээ дефолтод ороод байв. Монголбанкнаас мөнгөний бодлогыг оновчтой хэрэгжүүлж чадсаны үр дүнд эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэртэй байдлыг хангах замаар нөөц хуримтлагдахад чухал үүрэг гүйцэтгэснээр импортын 9 сарын хэрэгцээг хангах түвшинд хүргэн нэмэгдүүллээ.



Валютын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Монголбанк нь “Алт” хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн ажиллаж, алтны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, алтыг орон нутаг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, энэ хүрээнд алтны сорьцын лабораторийг байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Монголбанк 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авч түүхэн амжилтуудыг тогтоосон ба энэ эх үүсвэрээс жил бүр 700-800 сая ам.доллараар ГВАН-ийг нэмэгдүүлэв. Мөн томоохон экспортлогч компаниудтай хэлцэл хийх замаар гадаад валют худалдан авч, гадаад валютын нөөцийг арвижуулж байна. Цаашлаад дотоодын банкуудын гадаад зах зээлээс санхүүжилт татахад дэмжлэг үзүүлж, гадаад валютын дотогшлогч урсгалыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

ГВАН нэмэгдсэн нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт итгэх итгэлийг сэргээж, улсын эрсдэлийг бууруулж, санхүүгийн дархлааг нэмэгдүүлж, зээлжих зэрэглэлд эерэгээр нөлөөллөө. Тухайлбал, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 онд нэмэгдүүлж, Fitch болон S&P агентлагууд 2016 оны хүндрэлийн өмнөх түвшинд хүргэн сайжрууллаа. Монголбанк нь Засгийн газартай хамтран зэрэглэл тогтоогч байгууллагуудад эдийн засаг, гадаад валютын нөөц, санхүүгийн зах зээлд гарч буй эерэг өөрчлөлтүүд, тэдгээрийн суурь шалтгааныг тухай тайлбарлаж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлд нягт хамтран ажиллаж ирлээ.

Монголбанкны өөрийн хөрөнгийн алдагдлыг 1.5 их наяд төгрөгөөр буурууллаа. Төв банкны санхүүгийн сахилга батыг дээшлүүллээ.

Монголбанкны хуримтлагдсан алдагдал 3 их наяд төгрөг байсан. Алдагдлыг бууруулахгүйгээр банк тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. Тиймээс алдагдлыг бууруулах чиглэлээр эрчимтэй ажилласан. 2019 оны 3 дугаар улирлын тайлангийн үр дүнгээр алдагдлыг 2 дахин бууруулж 1.5 их наяд төгрөгт хүргэлээ.

Төв банкны хараат бус байдлын нэг үндсэн тулгуур нь санхүүгийн эрүүл байдал юм. Гэвч Монголбанк 2012-2016 онуудад алдагдалтай ажиллаж ирсэн нь эрсдэлийг нэмэгдүүлээд байв. Эдгээр он жилүүдэд Монголбанк төсвийн шинж чанартай хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлж, гадаад валютын өрийг нэмэгдүүлсэн нь нийтдээ 3 их наяд төгрөгийн хуримтлагдсан алдагдалд хүргээд байв.

Харин сүүлийн 3 жил гаруйн хугацаанд Монголбанк улс орныг гадаад валютын өрөнд оруулсан, өнгөрсөн жилүүдийн бодлогын алдааг давтахгүй байх зарчмыг баримтлан ажиллаж ирлээ. Түүнчлэн, гадаад захын тогтвортой байдлыг хангах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд санхүүгийн хэрэгслүүдийг шаардлагатай тухай бүр зах зээлийн нөхцөлөөр гэрээ байгуулан, ашиглаж ажиллалаа.



Гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, алдагдалтай санхүүгийн хэлцэл хийхгүй, санхүүгийн сахилга батыг хангаж ажилласны үр дүнд 2017, 2018, 2019 онуудад ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгө -3 их наяд төгрөг байсныг 1.5 их наяд төгрөгөөр бууруулж, -1.5 их наяд төгрөгт хүргээд байна. Төв банкны алдагдал ийнхүү буурахад Эрдэнэсийн санд хадгалагдаж буй түүхийн хосгүй үнэт эд зүйлс болон бусад үзмэрт анх удаа олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэсэн нь голлох нөлөө үзүүлэв. Өнөөгийн баримталж буй зарчим, үйл ажиллагааг цаашид хадгалан ажиллавал Монголбанк 2019 болон 2020 онд үргэлжлүүлэн ашигтай ажиллах бөгөөд цаашид Төв банкны өөрийн хөрөнгийг эерэг болгох зорилт тавин ажиллаж байна.

Банкны салбарын бүрдүүлэх хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэв. Эрүүл банкны салбар нь эрүүл эдийн засгийн суурь, эрүүл эдийн засаг нь эрүүл нийгмийн суурь юм.

Арилжааны банкуудын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр эрчтэй арга хэмжээ авч ажиллалаа. Эрүүл банк эрүүл эдийн засгийн үндэс. Эрүүл эдийн засаг бол эрүүл нийгмийн үндэс гэсэн зарчмыг гаргаж ажилласан. Банкны салбарт активын чанарын иж бүрэн үнэлгээ хийлээ. Өөрийн хөрөнгийн дутагдлыг нь тодорхойлж, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх даалгавар өглөө. Өөрийн

хөрөнгийг нь нэмэгдүүллээ. Нэмэгдүүлсэн эх үүсвэр дээр нь форензик буюу магадлан шалгах аудит хийлээ. Энэ бол сүүлийн 3 жилд Монгол Улсын банкны салбарт хийгдсэн томоохон шинэчлэл юм.

Авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд эдийн засаг сэргэж, банк санхүүгийн салбарын активын хэмжээ 35.5 их наяд төгрөгт хүрч, 16 хувиар өссөнөөр ДНБ-ний 104.2 хувьд хүрлээ. Банкууд зээл олголтоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөрвөх чадвар өндөртэй активыг хангалттай түвшинд барьж байгаа нь активын зохистой удирдлага, төлбөрийн чадварын эрсдэл даах чадварыг ахиулахад түлхэц болж байна.

Чанаргүй зээлийг бууруулж, түүнд түгжигдсэн хөрөнгийг санхүүгийн зуучлалд оруулах чиглэлд онцгой анхаарал хандуулж, "Чанаргүй зээлийг бууруулах стратеги"-ийг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар батлан, хамтран хэрэгжүүлж байна. Мөн Активын удирдлагын компанийн хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн бариулахаар хууль санаачлагчид хүргүүлээд байна.

Сүүлийн жилүүдэд банкууд хэрэглээний зориулалттай зээлийг ихээр олгож, зээлээр санхүүжүүлсэн худалдан авалт нэмэгдэж, өрхүүд өрийн дарамтад орох бодит эрсдэл үүсч эхлэв. Иймд Монголбанкнаас нэг талаас хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулах, нөгөө талаас бизнесийн зээлийн өсөлтийг дэмжих зорилгоор хэрэглээний зээлийн хугацааг бууруулах, шаардлагыг чангаруулах макро зохистой бодлого хэрэгжүүлсэн нь тодорхой үр дүнд хүрч байна. Тухайлбал, 2017-2018 онд зээлийн өсөлтийн 80 хувийг иргэдийн зээл бүрдүүлж байсан бол 2018-2019 онд энэ үзүүлэлт 58 хувь болж буураад байна.

ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Ази тивд анх удаа Активын чанарын үнэлгээг Европын Төв банкны стандартын дагуу хийлээ. Үүний үр дүнд үндэслэн банкны эрсдэл даах чадварыг сайжруулах чиглэлд хүчин чармайлт гаргасны үр дүнд нийт 10 банк 535.4 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн нь банкны салбарт тогтвортой байдал хадгалагдахад чухал нөлөө үзүүлээ.

Төлбөрийн системийн шинэчлэлийг хэрэгжүүлж олон улсын түвшинд хүрлээ. Улс орны мөнгөн урсгалын цөм нь тасралтгүй найдвартай төлбөр тооцооны үйл ажиллагаа байдаг.

Төлбөрийн систем нь улс бүрийн хувьд онцгой ач холбогдолтой, аюулгүй байдлыг чухалчлан хангаж байх ёстой онцгой дэд бүтэц юм. Тийм учраас аливаа улсын төлбөр тооцооны дэд бүтэц, үндсэн системүүд тухайн улсынхаа Төв банкны хяналтад байдаг ба үндэсний аюулгүй байдалд онцгой нөлөөтөйд тооцогддог.


Монголбанк Төлбөрийн системийн реформын хүрээнд хэд хэдэн томоохон ажлуудыг 2017 оноос хойш хийж, цоо шинэ түвшинд хүргэв. Юун түрүүнд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаар Монгол Улсын төлбөр тооцоонд шинэ хуудас нээгдсэн бөгөөд үүнтэй уялдаж хэд хэдэн журмууд гарлаа. Мөн Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлснээр Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийг бэхжүүлэх, банк дундын төлбөрийн системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор Үндэсний цахим гүйлгээний төвийн барилгыг олон улсын стандартын шаардлага хангасан, орчин үеийн дата төвийн барилгын жишигт нийцүүлэн бариулж эхэллээ. Түүнчлэн Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд дата төвүүдийг шинэчлэх, нууцлал аюулгүй байдлын төвийг байгуулах зэргийг үе шаттай хэрэгжүүлж орон нутаг дахь Үндэсний цахим гүйлгээний төвийн нөөц дата төвийг шинэчиллээ.

Үндэсний цахим гүйлгээний төвийн системээр дамжуулан хийгддэг, иргэдийн өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дээд хязгаар 1 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 3 сая

төгрөг болгон шинэчлэн тогтоолоо. Мөн банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг сольж, олон улсын стандартад нийцсэн Автомат Клиринг Хаус буюу АСН+ системийг нэвтрүүллээ. АСН+ системийг нэвтрүүлснээр иргэд, аж ахуй нэгжүүд банк хоорондын шилжүүлгийн төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэх, ижил төрлийн гүйлгээг багцлах, дебит шилжүүлэг хийх, системийн оролцогчдыг эрсдэлээс хамгаалах зэрэг олон давуу талыг бий болголоо.

Улмаар гүйлгээ дамжуулах хурдыг гурав дахин нэмэгдүүлж, төгрөгтэй адилтгах бэлэн бус төлбөрийн хэрэгсэлд анхны тусгай зөвшөөрлийг олгож, санхүүгийн байгууллагад зориулан цахим орчинд дамжуулах баримт бичгийн бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг баталгаажуулах дижитал технологийг нэвтрүүлэв. Эдгээрийн үр дүнд төлбөр тооцооны үйл ажиллагааны аюулгүй байдлыг нэмэгдүүлж, илүү хялбар хүртээмжтэй болж чадлаа.

Өдгөө олон улсын төв банкуудад хэрэгжиж буй “Intellect Quantum Central Banking” цогц шийдлийг нэвтрүүлэх ажлыг Монголбанк эхлүүллээ. Тус шийдлийг бүрэн нэвтрүүлснээр банкны үйлчилгээ, төрийн үйлчилгээ, мөнгөний бодлого, валютын ханшийн удирдлага, гадаад худалдаа, интернет банкны үйлчилгээ, нөөцийн удирдлага, төсвийн удирдлага гэх мэт хоорондоо нягт уялдаа бүхий удирдлагын модулиудыг нэгтгэх давуу талтай юм. Цаашид Үндэсний ₮ картын соронзон туузыг олон улсын стандартын дагуу чип болон зайнаас унших технологид шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа ба ингэснээр төлбөрийн картын нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах, шинэ дэвшилтэт төлбөрийн үйлчилгээг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.



MONETARY POLICY

ТӨВ БАНКУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ МӨНГӨНИЙ БОДЛОГО

Дэлхийн томоохон эдийн засгууд 2009 оны хямралыг даван туулснаас хойш өсөлтийн мөчлөг нь үргэлжилсээр 2019 оныг залгасан бөгөөд өдгөө энэхүү өсөлтийн эрч суларч, бүр зарим улсад агших хандлага давамгайлж байна. Мэдээж эдийн засгийн мөчлөг гэдэг ойлголт нь өсөлт болон уналтыг дотроо агуулж байдаг болохлоор тогтмол өсөлт гэдэг нь боломжгүйтэй адил зүйл. Нөгөөтээгүүр зах зээлд өсөлт эсвэл уналтын дараа тохируулга заавал хийгддэг бөгөөд энэ нь эдийн засагт, мөн макро бодлогод тусгалаа олдог. Тэгвэл эдийн засгийн нэг чухал бодлого болох мөнгөний бодлогын хандлага дэлхийн хамгийн том эдийн засагтай 3 бүсийн Төв банкуудад ямар байгааг үүгээр сонирхоцгооё.

ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТӨЛӨВ

Дэлхийн хамгийн том эдийн засаг сүүлийн 124 сар дараалж буюу 10 жилийн турш тэлж байгаа нь бусад улсуудад ч эерэгээр нөлөөлсөөр байна. АНУ-ын эдийн засгийн өсөлтийг 1854 оноос тооцож эхэлсэн бөгөөд 2009 оны 9-р сараас хойш улирлаар илэрхийлсэн ДНБ-ий өсөлтийн

хуримтлагдсан хэмжээ нь 25%-д хүрлээ. Хэдийгээр өмнөх өсөлтүүд шиг огцом байгаагүй боловч өсөлт тогтмол байснаар ажлын байрыг ч тэтгэж байна. АНУ-ын Төв банк нь инфляцийг онилохоос гадна бүрэн ажил эрхлэлтийг зорьдог. 2009 оны 10-р сард ажилгүйдлийн түвшин 10% буюу дээд хэмжээндээ хүрч байсантай харьцуулахад өдгөө 3.7% хүрээд байгаа нь түүхэн дэх хамгийн бага үзүүлэлт юм. Эдгээр эерэг өөрчлөлт болон төсвийн зөөлөн бодлогыг дагаад эдийн засаг халах буюу инфляцийн дарамт үүсэх эрсдэл үүссэний улмаас Холбооны нөөцийн банк 2016 оны сүүлээс 2018 оны эхний хагас хүртэл мөнгөний бодлогын төлөвийг тогтмол чангаруулж хүүг 2.5%-д хүргэсэн.

Өдгөө эдийн засаг өсөлттэй байгаа хэдий ч цаашдын төлөв сөрөг, бүүдгэр байгааг олон улсын байгууллагууд анхааруулж байгаагийн зэрэгцээ АНУ, БНХАУ-ын худалдааны дайн өрнөөд байгаа нь тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж байна. Трампын зүгээс худалдааны дайны хажуугаар долларын ханшийг бууруулж, худалдааны давуу тал бий болгохын тулд Холбооны нөөцийн банкыг хэд хэдэн удаа шахсан

боловч буулгаагүй бодлогын хүүг 2019 оны 6-р сард бууруулсан. Улмаар 10-р сарын 30-ны мэдэгдлээрээ бодлогын хүүг энэ онд 3 дахь удаагаа буулгав. Энэ нь хүлээлттэй нийцтэй байгаа. Төв банкны санхүүжилтийн хүү тогтмол биш буюу 0.25 хувиар хэлбэлзэх зохицуулалттай байдгийн хувьд өдгөө 1.5%-аас 1.75%-ийн хооронд тогтож байна. Бодлогын хүүг ийнхүү энэ жил нийтдээ 0.75%-аар бууруулж байгаа гол шалтгаан нь АНУ-ын аж үйлдвэрийн салбар удааширч, бизнесийн хөрөнгө оруулалт сул байгаатай холбоотой аж. Мөн худалдааны хурцадмал байдал нь АНУ-ын экспорт, хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлөн өгөөжийн муруйг урт хугацаанд урвуу болгоод байна. Гэхдээ эдийн засагт ажилгүйдлийн түвшин бага хэвээр байгаа, инфляци дунд хугацаанд зорилтот 2%-д дөхөх учраас цаашид бодлогын хүүг буулгах мессежийг сүүлийн мэдэгдлийн үеэр өгсөнгүй.

ЕВРОПЫН ТӨВ БАНК ХААШАА ЗҮГЛЭЖ БАЙНА ВЭ?

Европын Төв банкны тэргүүн Марио Драгигаар ахлуулсан мөнгөний бодлогын зөвлөл 9-р сарын 12-ны өдөр хуралдаж

бодлогын хүүг 0.1%-аар бууруулж -0.5%-д хүргэлээ. Европын Төв банк 2008 оноос хойш эдийн засгийг тэтгэхийн тулд хэт зөөлөн мөнгөний бодлого баримталж, бодлогын хүүг хасах түвшинд барьж ирсэн. Мөн уламжлалт бус мөнгөний бодлого буюу актив худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж сар бүр 30 тэрбум ам.долларын бонд худалдаж авч байсан. Сүүлийн жилүүдэд Дэлхийн санхүүгийн хямралын нөлөө буурч, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд Евро Бүсэд сайжирч эхэлснээр Европын Төв банк 2018 оны 12-р сард шинэ эх үүсвэрээр сар бүр 30 тэрбум ам.долларын актив худалдан авахаа зогсоож, өмнө нь худалдаж авсан бондын хугацаа дуусах үед дахин санхүүжүүлэх замаар ажиллахаа мэдэгдсэн. Гэтэл 2019 оны 9-р сард ихээхэн зөрчилтэй шийдвэрийг Европын Төв банк гаргасан.

Хамгийн сүүлд Европын Төв банк бодлогын хүүгээ 2016 оны 3-р сард -0.3% хүргэсэн байдаг. Тэгвэл 3.5 жилийн дараа хүүг 0.1 хувиар бууруулж -0.4 хувьд хүргэлээ. Үүнтэй зэрэгцэж бонд худалдаж авах ажиллагааг сэргээж 11-р сарын 1-ээс 20 тэрбум еврог зарцуулахаа зарласан. Эдгээр шийдвэр нь мөнгөний эргэлтийг ихээхэн хэмжээгээр эрчимжүүлэх нь гарцаагүй. Гэхдээ уг шийдвэрийг гаргахын тулд мөнгөний бодлогын гишүүд нь хурц маргалдаан өрнүүлж, эцэс сүүлд нь Герман Улсыг төлөөлж суудаг эрхэм ажлаа өгөхөө мэдэгдсэн. Мөнгөний бодлогын протоколоос үзэхэд Германаас гадна Франц, Голланд, Австрийн төлөөллүүд мөнгөний бодлогын шийдвэрийн эсрэг байгаа нь илэрхий байсан бөгөөд

эдийн засгийн багтаамжаар нь авч үзвэл эдгээр улсууд нь Европын холбооны эдийн засгийн талаас илүү хувийг бүрдүүлдэг.

Евро бүсийн мөнгөний бодлогын төлөвт тодорхойгүй байдал давамгайлж байна. Дэлхийн 4 дэх, Европын хамгийн том эдийн засаг Германы хувьд нөхцөл байдал таагүй байгаа. Аж үйлдвэрийн индексүүд унаж, худалдааны сектор удааширч байгаа тус улсын хувьд эдийн засаг нь хоёр улирал дараалж агшин техникийн хувьд ресешн буюу хүндрэлд орсон. Мөн яг энэ үед Төв банкны тэргүүн Драгигийн үүрэгт хугацаа дуусч, түүний орыг ОУВС-ын тэргүүн асан Кристин Лагард залгаж байна. Лагардын хувьд Дэлхийн хамгийн чухал Төв банкуудын нэгийг хэрхэн удирдаж, мөнгөний бодлогыг чиглүүлэх нь хараахан тодорхой болоогүй байгаа ч Европын Төв банкны мөнгөний бодлогын зөвлөлийн 10 сарын хурлаар төлөвийг хэвээр үлдээж, инфляцийг зорилтот түвшинд буюу 2%-тай ойр боловч түүнээс бага түвшинд хүргэхийн төлөө ажиллахаа мэдэгдлээ.


ХЯТАДЫН АРДЫН БАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ ТОГТВОРТОЙ БАЙНА

Дэлхийн Төв банкууд бодлогын хүүгээ бууруулах чиглэлд шийдвэрүүдээ гаргаж байхад БНХАУ-ын Ардын банк буюу Төв банкнаас суурь хүүгийн түвшингээ 10 сард хэвээр үлдээхээр шийдвэрлэлээ. Хятадын Ардын банк мөнгөний бодлогын суурь хүүг хамгийн сүүлд 2019 оны 9 сард 0.15-аар бууруулж 4.2%-д хүргэсэн. Энэ нь 2015 оны 10 сараас хойш анх удаа өөрчилж

байгаа явдал аж. Гэхдээ тус Төв банкнаас банкуудынхаа заавал байлгах нөөцийн хэмжээнд тохируулга хийж, бууруулах замаар бодлогын төлөвийг зөөлрүүлэх арга хэмжээг авч эдийн засагт шаардлагатай санхүүжилтийг чөлөөлдөг. Тухайлбал 2018 онд 17.0% байсан томоохон банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг удаа дараа бууруулж 2019 оны 1 сард 13.5%-д хүргэсэн. Цаашлаад энэ оны 9-р сард гэнэтийн шийдвэр гаргаж энэ үзүүлэлтийг бүх банкуудад 0.5%-аар бууруулснаар томоохон банкуудын заавал байлгах нөөцийн харьцаа 13.0% болж 126.35 тэрбум доллартой дүйцэх хэмжээний банкны эх үүсвэр чөлөөлөгдөж байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээний мөнгийг арилжааны банкууд Төв банкны дансанд заавал хадгалах шаардлагагүй болж байгаа ба цаашид зээл болон бусад чиглэлээр зарцуулагдаж эргэлтэд орох юм.

Хятадын Ардын банк суурь хүүгээ бусад Төв банкуудтай адил сулруулахгүй байснаар БНХАУ-ын актив нь илүү өгөөжтэй болох учраас хөрөнгийн урсгалыг өөртөө татах нөлөөтэй. Нөгөө талаас тус төв банк суурь хүүний түвшинг өөрчлөхгүй байгаа ч заавал байлгах нөөцийн харьцаа болон бусад санхүүжилтийн арга хэлбэрээр эдийн засгийг дэмжих хандлагатай байсаар байгаа. Мэдээж энэ бүхэнд дэлхийн худалдааны дайн томоохон нөлөөтэй учраас хоёр талын хэлэлцээр цаашид хэрхэн өрнөхөөс бүх зүйл шалтгаалах болно.

ТӨВ БАНКУУДЫН



БОДЛОГЫН ХҮҮ



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

НОГООН ДАРА ЭХ

Санскрит: Дара
Түвэд: Должин
XIX зуун
Алт шармал, зэс
Жин: 392 гр
Өндөр: 13 см

Ногоон дара эх нь баруун мутраа өвдөг дээрээ тавьж өглөгийн, зүүн мутраа зүрхэн тушаа дээш өргөн, дэлбээлж буй бадам цэцгийн ишнээс барин, аврал өгөгч мутарлага үзүүлсэн амарлингуй дүр байдалтай. Тэргүүндээ эрдэнээр чимсэн алтан титэм асааж, бадам цэцгийн мандалд баруун хөлөө урагш жийсэн байдлаар заларна.





НЭН ТЭРГҮҮНД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Дэлхийн банк группийн Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан бүсийн ахлах мэргэжилтэн **ЗАВИАР ФОРНЕРИСТАЙ** ярилцлаа.

МОНГОЛ УЛСЫН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХАД ХАМГИЙН ЧУХАЛ ШИЙДЭЛ ЮУ БАЙНА ВЭ?

Нэн тэргүүнд хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Өнгөрсөн жилүүдэд бодлогын тогтворгүй байдлаас болж, хөрөнгө оруулагчдын итгэл ихээр суларсан байгаа. Энэ нь улс төрийн тогтворгүй байдлаас тусдаа бөгөөд Монголын хувьд бодлого эсвэл хууль эрх зүйн өөрчлөлтүүд ямар ч урьдчилсан анхааруулга, үндэслэл тайлбаргүй, хөрөнгө оруулагчдаас санал авалгүйгээр гэнэт гардаг нь хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж байна. Тийм ч учраас Олон улсын санхүүгийн корпораци нь Монголбанк болон Үндэсний хөгжлийн газартай хамтран “Хөрөнгө оруулалтын орчин: Тогтвортой байдал” сэдэвтэй олон улсын бага хурлыг зохион байгуулж байна. Хууль, зохицуулалт, бодлогын тогтвортой байдал гэдэг нь дотоод болон гадаад хөрөнгө оруулалтын орчинд маш чухал зүйл. Улмаар энэ нь эрх тэгш бөгөөд ил тод хэрэгжих боломжтой байх ёстой. Өөр улс орнуудад хууль, журамдаа өөрчлөлт оруулдаг ч гэсэн хөрөнгө оруулагч нарыг цочролд оруулахааргүй

байдаг. Ингэхийн тулд хууль эсвэл журмын төслийг олон нийтэд, тэр дундаа хувийн секторт танилцуулж, санал авах арга барилаар ажилладаг. Энэ бол тэргүүлэх чиглэл юм.

Хөрөнгө оруулагч нарын итгэлийг сэргээх чиглэлээр хийвэл зохих өөр нэг зүйл бол Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчдад хуулийн хүрээнд шударга, эрх тэгш, ил тод хандаж, ялгаварлан гадуурхлыг үл тэвчих зарчмаар ажиллана гэдгээ дахин баталгаажуулсан албан ёсны тунхаглал, эсвэл мэдэгдэл гаргавал зүйтэй. Энэ нь тийм урт байх албагүй бөгөөд хамгийн гол нь энэ чиглэлээр хүчин чармайлт гаргаж байгаагаа илэрхийлж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд хэрэг болохуйц байвал зохино.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ УЛС ОРНЫ ЭДИЙН ЗАСАГТ, ТУХАЙЛБАЛ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ ҮЗҮҮЛЭХ ХУВЬ НЭМРИЙГ ТАЙЛБАРЛААЧ?

Бидний хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг дотоодын хөрөнгө оруулалтаас тусад нь ялгаж авч үздэггүй. Хоёулаа л улс орны эдийн засагт чухал

нөлөөтэй. Үнэндээ Монголд дотоодын хөрөнгө оруулалт татах боломж илүү байдаг. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулалт нь хөгжлийн процессыг сууриар нь эрчимжүүлэх чадалтай байдгаараа онцлог. Түүгээр эдийн засгийн тодорхой секторт шинэ боломжууд болон технологийн дэвшлийг авчрах боломжтой. Гадаадын хөрөнгө оруулалт гэдгийг капитал гэдэг утгаас илүү өргөн хүрээнд ойлгох хэрэгтэй. Энэ нь эдийн засаг болон хувийн секторт ач тусаа өгөх технологи, ноу-хау, менежментийн ухааныг дагуулж байдаг. Цаашлаад дотоодын компаниудыг гадаад зах зээлтэй холбох түншлэлийг бий болгодог. Том дүр зургаар бол энэ нь тухайн улсын эдийн засгийг олон улсын зах зээлтэй холбох давуу тал юм. Дотоодын зах зээлд оролцогчид энэ боломжоор дутмаг. Тиймээс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дагаж олон зүйл явдаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

МОНГОЛЫН ХУВЬД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЬ УУЛ УУРХАЙН СЕКТОРД ИХЭЭХЭН ТӨВЛӨРСӨН БАЙНА. ҮҮНИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙН БУСАД СЕКТОРУУД ЛУУ ЧИГЛҮҮЛЭХ ТАЛААР БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ШИЙДЛИЙГ ЭРЭЛХИЙЛЖ БАЙНА. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН ЗҮГЭЭС ЭНЭ ЧИГЛЭЛД ЯМАР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ВЭ?

Мэдээж, эхлээд байгаа суурь дээрээсээ хөдөлбөл зүйтэй. Монголын хувьд дийлэнх гадаадын шууд хөрөнгө оруулалт нь байгалийн баялаг дээр байршиж байна. Тэгэхээр төвлөрлийг сааруулах стратегийн нэгдүгээр элемент нь бусад секторыг уул уурхайтай холбох замаар хөгжүүлэх ёстой. Тухайлбал, уул уурхайн компаниуд импортоор тоног төхөөрөмж гэх мэт зүйлсийг авдаг бөгөөд орон нутгийн компаниуд нь худалдан авах үйл ажиллагаанд оролцож, гүйцэтгэгчээр ажиллаж байгаа нь зөв. Цаашлаад бусад секторт хөрөнгө оруулалтын урсгалыг шууд чиглүүлэхгүй ч гэсэн уул уурхайн салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын өгөөжийг дээд хэмжээнд хүргэснээр дагаж ажиллаж байгаа секторуудыг тэтгэнэ.

Хоёрдугаарт, бидний хэлдгээр сектор скан гэдгийг хийх нь зөв бөгөөд ингэхдээ уул уурхайн салбараас бусад салбарын потенциалыг тодорхойлно. Монголын хувьд хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мах боловсруулах, сүү сүүн бүтээгдэхүүн, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлд ихээхэн нөөц бололцоо байна. Хөдөө аж ахуйн салбараас гадна аялал жуулчлал, бизнесийн

жуулчлал, мөн интернэт худалдаанд боломж байгаа. Гэхдээ нөөц бололцоог тодорхойлох нь хангалттай биш. Түүнээс цаадахыг харах хэрэгтэй. Ямар хүндрэл, бэрхшээл байгааг ойлгож түүнийг шийдвэрлэснээр хөрөнгө оруулалтыг бодитоор татаж чадна. Тэгэхээр тухайн улс оронд хууль эрх зүйн хүрээнд хязгаарлалт, хүндрэл байх юм бол хөрөнгө оруулалт орж ирэхгүй, тойрох болно. Тиймээс хуулийн болон бусад чиглэлээр реформ хийснээр хөрөнгө оруулалт орж ирэх болно.

Гуравдугаар элемент нь сурталчилж таниулах ажил юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах сурталчилгааны стратегийг олон секторт хэрэгжүүлэхэд үр дүн муутай байдаг учраас тухайлсан нэг салбарт төвлөрөх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, секторуудыг тэргүүлэх ач холбогдлоор ангилж, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, сурталчлах стратегийг хэрэгжүүлнэ. Тэгэхээр секторуудын нөөц бололцоо, хөрөнгө оруулалтын саад бэрхшээлийг тооцож, тодорхой стратегийг хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрч чадна.

МОНГОЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТАТВАР БОЛОН БУСАД ОРЧИН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХЭР ЭЭЛТЭЙ БАЙНА ВЭ? ХЭРЭВ АСУУДАЛ БАЙГАА БОЛ ЮУГ АНХААРВАЛ ЗҮЙТЭЙ ВЭ?

Миний бодлоор хамгийн том асуудал бол эрсдэл юм. Тогтворгүй байдлаас үүдэлтэй эрсдэл. Тэгэхээр Монголын хөрөнгө оруулалтын орчинд саад болж байгаа зүйлсээс энэ тэргүүнд бичигдвэл зохих нь тогтворгүй орчин, ил тод бус байдал. Мөн гадаад гэлтгүй дотоодын хөрөнгө оруулалтад ч саад болж байгаа зүйл байна. Татвар, ил тод байдал, дэд бүтцийн бэрхшээлүүд бол ерөнхий асуудал тул салбар бүрт хамааралтай. Зарим секторт илүү түлхүү саад болж байгаа хүндрэлүүд ч байна. Хэрэв аль нэг секторын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулъя гэвэл маш нарийн анализ хийх хэрэгтэй. Тухайлбал, аялал жуулчлалын салбарт тулгарч байгаа хүндрэл нь худалдааны секторын хүндрэлээс тэс өөр байж болно. Тиймээс асуудлыг том дүр зургаар үзээд дараа нь тэргүүлэх салбарт тулгарч буй хүндрэлээ гүнд нь орж шинжлэх нь зүйтэй.

ТА ТОДОРХОЙ АЛЬ НЭГ СЕКТОРЫГ ЖИШЭЭ БОЛГОН ТАЙЛБАРЛАЖ БОЛОХ УУ?

Би хөдөө аж ахуй, тэр дундаа махны үйлдвэрлэлийн сектор дээр ярья. Дотоодын үйлдвэрлэл болон экспортын хүрээнд Монгол Улсын түүх болон соёлыг харахад ихээхэн бололцоо байгаа. Гэхдээ бэлчээрийн

мал аж ахуй эрхэлдэг нь зарим талаар давуу тал болж болох ч нөгөө талаар махыг БНХАУ, ОХУ гэх мэт гадаад улс руу экспортлоход тодорхой стандартыг мөрдөх хэрэгтэй болдог. Хүнсний ариун цэврийн стандартууд хамгийн түрүүнд яригдана. Тэгэхээр баталгаажсан лаборатори, өндөр мэргэжлийн малын эмч, сайн дэд бүтэц, шаардлага хангахуйц хүйтэн агуулахтай байж энэ стандартууд хангагдана. Хэдийгээр Монголын махны үйлдвэрлэл сайн ч эдгээр стандартуудыг хангахгүй бол экспорт хийж чадахгүй. Үүнтэй адил бусад секторт ч өөр өөр асуудал байна.

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
НЭМЭГДСЭНЭЭР ТУХАЙН УЛСЫНХАА ЭДИЙН
ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ЯМАР НЭГ
БАЙДЛААР ЭЭРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛДЭГ ҮҮ?
НӨГӨӨ ТАЛААС ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ ХАНГАГДСАНААР ГАДААДЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ЯМАР ДАВУУ ТАЛ
ҮҮСЭХ ВЭ?**

Тэгэлгүй яахав энэ хоёр нь харилцан биедээ нөлөөлдөг. Макро эдийн засгийн тогтвортой байдал тодорхой хэмжээнд хангагдах нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах маш чухал үзүүлэлт болдог. Тухайлбал инфляци хэт өндөр биш, тогтвортой байх эсвэл валютын ханш огцом савладаггүй байх нь хөрөнгө оруулагчдад эерэг нөлөөтэй. Нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр макро эдийн засгийн тогтвортой байдлыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж чадна. Монголбанкнаас энэ талаар тодорхой тайлбарлаж байгаа. Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлж гадаад өрийн төлбөрийг гүйцэтгэхэд туслах болно.

**МОНГОЛЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД
ТАНД НЭМЖ ХЭЛЭХ, ОНЦЛОХ ЗҮЙЛ БАЙНА УУ?**

Тэгэхээр миний түрүүн ярьсан зүйлсийг нэгтгээд харахад бодлогын тогтвортой байдал ямар чухал нөлөөтэй болох нь ойлгомжтой байгаа болов уу. Олон улсын санхүүгийн корпорациас Монголын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахад хэрэг болохуйц хэрэгслүүдийг багтаасан Хөрөнгө оруулалтын реформын зураглал буюу IRM тайланг гаргасан. Тус тайланд ашиглаж болохуйц хэд хэдэн арга хэрэгслүүд багтсан байгаа. Тэдгээрээс дурдвал, нэгт Засгийн газраас хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон мэдэгдэл гаргах нь маш чухал. Энэ нь хөрөнгө оруулалтын бодлогод гарах өөрчлөлтийг тодорхой байдлаар зарлах үйл ажиллагаа юм. Үүнд хөрөнгө оруулалтыг хэрхэн авах, хандах, зохицуулах талаар ил тод дурдаж, ямар хүчин чармайлт гаргахыг заана. Энэ бол маш тодорхой хэрэгсэл бөгөөд хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхийн тулд Засгийн газраас хийж чадах маш чухал зүйл.

Хоёрт, хөрөнгө оруулагчдын гомдол, асуудлыг шийдвэрлэх үйл явцыг сайжруулах талаар байгаа. Засгийн газраас энэ хүрээнд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг 2016 онд байгуулсан, мөн 2018 онд холбогдох хуулинд энэ чиглэлээр заалт оруулсан. Гэхдээ энэ бүхэн төдийлөн хангалттай биш байгаа. Засгийн газраас энэ тал дээр илүү их анхаарч, хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх механизмыг бүхлээр нь хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Тэгж байж сая хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой байлгахад хүчин чармайлт гаргаж байгааг харуулах ба улмаар хөрөнгө оруулалтыг ч нэмэгдүүлэх юм.

Танд баярлалаа.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 24/Х ӨДРИЙН БАЙДЛААР)**

tth



МОНГОЛБАНКНЫ

Дурсгалын зоос

Он: 1974

Нэрлэсэн үнэ: 10 төгрөг

Металл: Мөнгө 999

Жин: 50 гр

Голч: 50 мм

ҮНДЭСНИЙ БАНКНЫ 50 жилийн ойд зориулсан зоос

Монгол улсын дурсгалын зоос хагас зуу орчим жилийн түүхэн уламжлалтай. Монгол улс хүн төрөлхтний ба өөрийн улс орны түүхэн тэмдэглэлт ой, түүхт хүмүүс, соёлын өв, байгалийн өв, онцлог үйл явдал, соёл урлаг, спортын амжилтад зориулан олон төрлийн дурсгалын зоос гаргажээ. Дурсгалын зоосыг алт, мөнгө, цагаан алт зэргээс гадна зэс, никель, гууль зэрэг өнгөт төмөрлөгөөр үйлдвэрлэж байна.





МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН 2019-2020 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Б.Дуламзаяа, Г.Ганчимэг, Ч.Номуундарь, Б.Эрхэмбаяр

1. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл

Манай улсын төлбөрийн тэнцлийн урсгал данс 2019 оны эхний дөрвөн данс 592 сая ам.долларын ашигтай гарч, нийт төлбөрийн тэнцэл 323 сая ам.долларын ашигтай гарлаа.

Төлбөрийн тэнцлийн 2019 оны эхний 4 сарын гүйцэтгэлийг өмнөх улиралд хийсэн төсөөлөлтэй харьцуулбал:

- Урсгал данс өмнөх төсөөллөөс бага алдагдалтай гарахад зэс (Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж оны эхэнд хүлээлтээс өндөр байсан), нүүрс, төмрийн хүдэр, ноолуур, мах, махан бүтээгдэхүүний экспорт хүлээлтээс нэмэгдсэн нь эерэгээр нөлөөллөө. Харин санхүүгийн үйлчилгээний зардал өссөн, гадаад зээл, бондын хүүний зардал хүлээгдэж байснаас давсан зэрэг нь урсгал дансны алдагдлыг өсгөх нөлөөтэй байв.
- Санхүүгийн дансны хувьд ГШХО төсөөллөөс өндөр гүйцэтгэлтэй байсан бол бусад хөрөнгө оруулалтын цэвэр урсгал төсөөллөөс бага түвшинд байлаа. Тухайлбал, (i) бэлэн мөнгө, харилцах дансны цэвэр урсгал 60 сая ам.доллар байхаар төсөөлж байсан боловч 309 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай байсан, мөн худалдааны зээлийн бараагаар эргэн төлөлт хийсэн дүн өндөр байсан зэрэг нь бусад

хөрөнгө оруулалтын урсгал төсөөллөөс бага гарах суурь шалтгаан боллоо.

2. Төлбөрийн тэнцлийн төсөөлөл 2019-2020 он

Суурь төсөөллөөр төлбөрийн тэнцэл 2019 онд 557 сая ам.долларын ашигтай, 2020 онд 66 сая ам.долларын алдагдалтай гарахаар байна.

Төлбөрийн тэнцэл 2019 онд ашигтай гарахад:

- Экспортын үнэ оны сүүлийн хагаст буурах хэдий ч нүүрсний экспорт 39 сая тоннд хүрч нэмэгдэх, энэ оны эхэнд "МИК ОССК" ХХК-ийн гадаад зах зээл дээр арилжаалсан 300 сая ам.долларын бондын орлого болон ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хандивлагч орнуудын зүгээс олгохоор хүлээгдэж буй санхүүжилт зэрэг нь гол эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Төлбөрийн тэнцэл 2020 онд алдагдалтай гарахад:

- Экспортын түүхий эдийн үнэ сэргэхгүй, Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж буурах нөлөөгөөр экспортын орлого багасах нь урсгал дансны алдагдал өсөхөд нөлөөлнө. Санхүүгийн дансны хувьд ХХБ-ны гадаад бонд болон БНХАУ-ын Ардын Банкны своп хэлцлийг дахин сунгахаар таамагласан тул 2019 онтой харьцуулахад багцын хөрөнгө оруулалтын дансны цэвэр орох урсгал бага байна.

Хүснэгт 1. Төлбөрийн тэнцэл (2019-2020 оны төсөөлөл)

Үзүүлэлт	2018		2019*		YoY (%)	2020*		YoY (%)	
	Жил	YoY (%)	Төсөөлөл			YoY (%)	Төсөөлөл		
			өмнөх	одоогийн			өмнөх		Одоогийн
I. Урсгал данс	-1,902	65%	-2,072	-2,312	22%	-2,509	-2,629	14%	
Бараа	685	-54%	528	795	16%	30	297	-63%	
Экспорт	6,557	12%	6,784	7,105	8%	6,455	6,548	-8%	
Импорт	5,871	35%	6,256	6,310	7%	6,425	6,251	-1%	
Үйлчилгээ	-1,449	20%	-1,560	-1,914	32%	-1,490	-1,832	-4%	
Анхдагч орлого	-1,423	-12%	-1,309	-1,515	6%	-1,318	-1,392	-8%	
Урсгал шилжүүлэг	284	58%	270	322	13%	270	299	-7%	
II. Хөрөнгийн данс	88	13%	101	102	16%	94	95	-6%	
III. Санхүүгийн данс	1,800	-10%	2,543	2,704	50%	2,245	2,467	-9%	
ГШХО	1,924	33%	1,616	1,813	-6%	1,724	1,895	5%	
Багцын ХО	37	-93%	223	352	856%	-31	37	-89%	
Бусад ХО	-173	-328%	699	554	-421%	549	551	-1%	
Худалдааны зээл	78	-283%	-67	-88	-213%	-39	-64	-27%	
Зээл	-139	-63%	966	914	-758%	787	815	-11%	
Урт хугацаат, цэвэр	-52	-65%	995	1,016		769	818	-20%	
Богино хугацаат, цэвэр	-133	-15%	-74	-103	-22%	-24	-6	-94%	
Бэлэн мөнгө, харилцах	-112	-123%	-200	-272	144%	-200	-200	-26%	
Санхүүгийн ҮХэрэгслүүд	13		6	-15		3	-16		
IV. Алдаа, орхигдуулга	-127		0	63		0	0		
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ	-141		573	557		-170	-66		

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

3. Төлбөрийн тэнцлийн төсөөлөлд ашигласан гол таамаглал

Экспорт

Нүүрс. Нүүрс экспортлогч томоохон компаниудаас авсан мэдээгээр 2019 онд нүүрсний олборлолт өмнөх оноос нэмэгдэж, нүүрсний экспорт 40 сая тонн хүртэл нэмэгдэх боломжтой байна. Төсөөллийн хугацаанд Гашуун-Сухайт боомтоор нэвтрэх нүүрс тээвэрлэлт саадгүй хэвийн үргэлжилж, тус боомтоор жилд 20 сая тонн нүүрс экспортолно гэж үзэв. 2019 оны эхний дөрвөн сард 11.4 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх төсөөлөлтэй нийцтэй тул нүүрсний экспорт 2019 онд өмнөх оноос 3.2 сая тонн (8.9 хувь)-оор өсч 39.2 сая тонн, 2020 онд 39.0 сая тоннд хүрэх төсөөллийг хэвээр хадгаллаа. 2018 онд нүүрс угаах үйлдвэрүүд ашиглалтад орж, баяжуулсан нүүрс боловсруулах хүчин чадал нэмэгдсэн ч одоогоор баяжуулсан нүүрсний экспорт нэмэгдээгүй, туршилт үйлдвэрлэлүүд явагдаж байна.

Зэс. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн мэдээлснээр зэсийн баяжмалын олборлолт, экспорт төсөөллийн хугацаанд 2018 оны түвшинд байхаар байна. Гэхдээ хүдэр дэх зэсийн агууламж аажим буурах хандлагатай байна.

Оюу толгой ХК-ны ирүүлсэн мэдээллээр ил уурхайгаас олборлох зэсийн баяжмалын хэмжээ уулын ажилтай уялдан 2019 онд буурч, 2020 онд бага зэрэг сэргэхээр байгаа бөгөөд зэсийн баяжмал дахь алтны агууламж 2019 оны эхний хагаст өсч, сүүлийн хагаст буурах, 2020 онд мөн буурахаар байгаа нь төсөөллийн гол зөрүүг тайлбарлаж байна. АНУ, БНХАУ-ын худалдааны зөрчилдөөн ширүүссэн нөлөөгөөр дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ буурсан, зэсийн экспортын биет хэмжээ ийнхүү буурах нөлөөгөөр зэсийн экспортын орлого 2019 онд өмнөх оноос 20 хувиар, 2020 онд 9 хувиар буурахаар төсөөллөө.

Импорт

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт: Түргэн эдэлгээт хэрэглээний бараа (дийлэнх нь хүнсний бүтээгдэхүүн)-ны импорт I улиралд төсөөллөөс доогуур байсан нь 2019 оны өсөлтийг өмнөх төсөөллөөс бууруулахад нөлөөллөө. Эхний улирлын гүйцэтгэлээр суудлын автомашины импорт төсөөллөөс 11 нэгж хувиар давж өссөн бол бусад төрлийн удаан эдэлгээт бараа буюу гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилгын импорт төсөөллөөс доогуур байж өмнөх оны I улирлаас хоёр хувиар буурлаа. Энэхүү гүйцэтгэлийг ашиглан цаашдын

төсөөллийг шинэчилснээр 2019 онд удаан эдэлгээт барааны импорт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна. Улмаар нийт хэрэглээний бүтээгдэхүүний импортын хэмжээ өмнөх төсөөллөөс нэг нэгж хувиар өндөр байхаар төсөөлж байна. Харин 2020 оны төсөөлөл суурь үнийн нөлөөгөөр өөрчлөгдөнө.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Тус дансны төсөөллийг боловсруулахдаа томоохон төсөл хөтөлбөрийн мэдээлэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ, импортын төсөөлөл болон ГШХО-ын өнгөрсөн хугацааны тоон мэдээллийг орц болгон ашиглалаа. ГШХО-ын хэмжээ 2018 онд 2,137 сая ам.доллар байсан бол 2019 онд 1,813 сая ам.доллар, 2020 онд 1,895 сая ам.доллар болж буурахад Оюу толгой болон бусад ААН-үүдийн ГШХО-ын хэмжээ өмнөх оноос буурахаар хүлээгдэж байгаа нь нөлөөллөө.

Оюутолгой компанийн гүний уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд 2019-20 онуудад ГШХО 2018 оны түвшинд орж ирэхээр хүлээгдэж байна.

Засгийн газрын концессээр хийгдэх дэд бүтцийн төсөл (Тавантолгойн болон 5 дугаар Цахилгаан станц)-үүдийн санхүүжилтийн нөхцөл байдал тодорхойгүй байна.

Бусад ААН-ийн ГШХО-ын хувьд 2018 онд 653 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байв. Харин ирэх онуудад уул уурхайн компаниудын капиталын импортын эрэлт багассанаар тэдний ГШХО-ын шаардлага багасч 2019 онд нийт 306 сая ам.доллар, 2020 онд 335 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байна гэж авч үзлээ.

Төлбөрийн тэнцлийн төсөөллийн эрсдэл, тодорхой бус байдал

- Эрдэнэс Таван Толгой ХК төсөөллийн хугацаанд гадаад зах зээл дээр IPO гаргах замаар хөрөнгө оруулалт татах нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлнө.
- Зүүнбаян-Хангимандалын төмөр замын бүтээн байгуулалт дотоодоос санхүүжилттэй хэрэгжих нь импортыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд дарамт үзүүлэхээр байна.
- АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан ширүүсч хоёр орны өсөлт саарвал түүхий эдийн үнэ төсөөллөөс буурч болзошгүй.
- Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орох тохиолдолд манай зээлжих зэрэглэл буурах, улмаар хөрөнгийн урсгал татарч, төгрөгийн ханш сулрах, гадаад валютын нөөц буурах эрсдэлтэй.
- ОУВС-гийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагууд, донор орнуудаас олгох санхүүжилт цаг хугацаандаа хийгдэхгүй хойшлох нь мөн төсөөлөлд сөргөөр нөлөөлнө.



ХУРИМТЛАЛ ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хурим найр зэрэг баярт үйл явдлууд, эсвэл өвчин зовлон тохиолдсон үед, аялах болон сурах зорилгоо биелүүлэх гээд мөнгөний хэрэгцээ гарах үе хүний амьдралд бишгүйдээ л тохиолддог. Энэ үед мөнгөн хуримтлалгүй тохиолдолд бусдаас зээлэхээс өөр сонголтгүй. Мэдээж зээлсэн мөнгийг дараа нь эргүүлж төлөх шаардлагатай. Мөн зээл нь ирээдүйн орлогоо урьдчилж хэрэглэсэн гэсэн үг бөгөөд зээлээ төлөх үед бүсээ чангалж амьдарна гэсэн үг. Түүнчлэн мөнгийг авч ашигласны төлбөр болох хүүгийн зардал төлөх шаардлагатай болдог. Эндээс бүсээ чангалаад зээлийг хүүтэй нь төлж чадаж байгаа хүн болгон хичээвэл хуримтлал үүсгэх боломжтой гэдэг нь харагдана. Зээлэхийн оронд хуримтлал хийснээр хүүгийн зардал хадгаламж болж өөрт үлдэнэ, банкнаас өөрөө хүү авна. Тэгэхээр, хуримтлал бол цалингийн их бага гэхээсээ санхүүгийн сахилга батын л асуудал юм. Хуримтлалтай байх нь тэтгэвэрт гараад орлого хумигдах үед, эсвэл хүүхдүүд том болж сургуульд орох үед, өөр амьдралын олон чухал тохиолдолд санхүүгээрээ сонголттой хязгаарлахгүй байх боломжийг олгоно.

Мөнгөө хуримтлуулах үед “яаж хурдан өсгөх вэ?”, “яавал найдвартай вэ?” гэдэг 2 асуулт чухал юм. Мөнгөө цуглуулж, өсгөнө гэдэг нь нэг төрлийн хөрөнгө оруулалт хийх шийдвэр учраас өгөөж болон эрсдэлийг харьцуулах сонголттой тулгарна. Сугалаа, мөрийтэй тоглоом, пирамид схем гэх мэт зарим зүйлс маш өндөр өгөөж амлах ч, дагаад маш өндөр эрсдэлтэй эсвэл бүр хууль бус байх нь бий. Хувьцаа, бонд, үнэт цаас,

банкны хадгаламж гэх мэт санхүүгийн зах зээл дээрх түгээмэл бүтээгдэхүүнүүд ч дотроо эрсдэл, өгөөжөөрөө ялгарна. Энэ үед “Бүх өндгөө нэг сагсанд бүү хий” буюу эрсдэлээ хуваарилан хөрөнгөө олон хэлбэрээр тараан байршуулах нь алтан дүрэм юм. Мөнгөө хуримтлуулахдаа өгөөж багатай ч маш найдвартай хувилбараас эхлээд, санхүүгийн чадавх нэмэгдэхийн хэрээр алдсан ч асуудалгүй мөнгөөрөө өндөр өгөөж хайх нь ухаалаг шийдвэр болно.

Хуримтлал хийж эхлэх нь заримдаа тийм ч амар зүйл биш байдаг. Гэхдээ энэхүү амаргүй байдлыг давах нь мөнгө хуримтлуулах зорилго, төлөвлөгөөгөө гаргахаас эхэлнэ. Хуримтлалыг нэг өдөрт биш алхам алхмаар хийх боломжтой.

Хуримтлал хэрхэн үүсгэх вэ?



1. Орлого, зардлаа бүртгэх.

Төсөв зохиох нь маш энгийн бөгөөд дараах зүйлсийг амьдралдаа хэвшүүлэх нь үр дүнтэй.

- Сарын тогтмол болон нэмэлт тогтмол бус орлогуудаа бүртгэх;
- Өдөр бүрийнхээ зарцуулалтыг гарын дор дэвтэр гаргаад ч юм уу эсвэл гар утсан дээрээ бүртгэх;

- Орлого, зардлаа бүртгэн өрхийн төсвөө гаргаарай.

Сарын орлого, зардлаа ийнхүү тооцох нь:

- Хэрвээ таны орлого зардлаасаа их байгаа бол та шууд хуримтлуулж эхлээрэй.
- Орлого тань зардлаасаа илүү гарахгүй бол зардлаа хэмнэх боломжийг хайгаарай. Мөн орлогоо нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлээрэй.

2. Хэмнэж болох зардлыг хасч орлого болон зардлын төлөвлөгөө гаргах.

Сарын эцэст зардал тус бүрийг нягтлан үзээд үр ашиггүй, илүү зардлаа танаж, хэмнэх боломж байгаа эсэхийг тодорхойл. Гэхдээ тэмдэглэлт баяр, төрсөн өдөр гэх мэт тогтмол бус нэмэлт зардлуудыг тусгахаа мартуузай. Мөн тогтмол орлого болон тогтмол бус орлого орж ирэх хугацаагаа нягталж, орлого нэмэгдүүлэх бодит боломжоо үнэлээрэй.

3. Хуримтлуулж чадах хэмжээгээ тодорхойлох.

Ийнхүү өрхийн төсвөө шинэчлэн гаргаж хуримтлал хийх боломжит хэмжээгээ тодорхойлно. Санхүүгийн мэргэжилтнүүд цэвэр орлогынхоо 10-15 хувийг хуримтлуулахыг зөвлөдөг. Мэдээж хуримтлал танд дарамт болж болохгүй. Хэмнэлт тань ухаалаг байх хэрэгтэй. Төсөв гаргаж, дээрээс нь хэмнэлт хийж сурсан байхад та санаанд оромгүй их мөнгийг хуримтлуулсан байх болно.

4. Хуримтлал хийх зорилгоо ач холбогдлоор нь жагсаан бичих.

Хүн бүрийн хувьд харилцан адилгүй хамгийн чухал зүйлтэй байх тул өөрийнхөө хувьд цаг хугацаа, хуримтлалын хэмжээнээсээ хамааруулан хуримтлалаа хийх нь чухал юм.

5. Урт, богино хугацааны хуримтлалын зорилгоос хамааруулан хуримтлалын хэлбэрээ сонгох.

Урт болон богино хугацааны зорилготойгоо уялдуулан хуримтлал хийх нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, зорилгуудыг дараах байдлаар урт болон богино хугацааных гэж ангилж болох юм. Үүнд: Богино хугацааны зорилгыг санхүүжүүлэхэд зориулсан хуримтлал /1-3 жилийн хугацаа/

- Гэнэтийн хэрэгцээнд зориулан хуримтлуулах /ажил хийхгүй байхдаа 6 сараас 1 жил амьдрах зардлаа нөхөх хэмжээний хуримтлал/
- Амралт зугаалга, аялалд зориулан хуримтлуулах
- Сурч боловсроход зориулан хуримтлуулах
- Шинэ машин худалдан авахад зориулан хуримтлуулах гэх мэт.



Урт хугацааны зорилгоо санхүүжүүлэхэд зориулсан хуримтлал /3 болон түүнээс дээш жилийн хугацаа/

- Тэтгэвэрт гарахдаа зориулан хуримтлал хийх
- Хүүхдийнхээ их дээд сургуулийн боловсролд нь зориулан хуримтлал хийх
- Байрны урьдчилгаа төлбөр бүрдүүлэх болон байрны засвар өргөтгөлд зориулан хуримтлуулах гэх мэт.

Урт болон богино хугацааны зорилгоосоо хамааруулан хуримтлалын бүтээгдэхүүний төрөл хэлбэрээ зөв сонгох нь илүү үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, урт хугацааны зорилгодоо хуримтлал хийж байгаа бол 1 жилээс дээш урт хугацаатай хадгаламжийг сонгох, богино хугацааны зорилгодоо хуримтлал хийх бол 1 жилээс доош богино хугацаатай хадгаламжийг сонгох нь төлөвлөсөн хадгаламжийн хүүний орлогоо эрсдэлгүйгээр (хадгаламжийн хугацаагаа цуцлуулж бага хүүтэй хадгаламж авахгүй) авах боломжийг бүрдүүлдэг.

6. Хуримтлалаа эхлүүлж, хэрхэн өсч байгааг хянаж байх.

Нэгэнт та хуримтлал хийхээр шийдсэн бол цалин болон орлогоосоо шууд хадгаламжийн данс руугаа тодорхой өдрүүдэд тогтмол дүнгээр мөнгөө автоматаар шилжүүлбэл илүү үр дүнтэй.

Эцэст нь таны хуримтлал таны төлөвлөгөөний дагуу өсөх болно. Хуримтлалтай болох дээрх үйл явцыг сар бүр хянаж, хуримтлал хийх төлөвлөгөөгөө хэрэгжүүлж чадвал хүссэн хэмжээний хуримтлалаа хийж санхүүгийн гэнэтийн эрсдэлээс өөрийгөө хамгаалж чадна.

Эцэст нь ирээдүйг хэн ч харж чадахгүй учраас санхүүгийн хувьд хүчтэй, өөртөө итгэлтэй, төлөвлөгөөтэй амьдрах нь аз жаргалтай амьдралын үндэс юм.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХАМТДАА ТАСЛАН ЗОГСООЁ !



Сэжигтэй, эх үүсвэр нь тодорхойгүй мөнгө ашиглаж байгаа болон мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ үү.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТЭС
Утас: 51-265794, 51-265734

Мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог

Илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл түүнийг хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг өөрчилснийг мөнгө угаах гэнэ.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДВОЛ ХУУЛИЙН ДАГУУ ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ АВНА



СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Иргэн Та мөнгө угаах гэмт хэргийг санаатайгаар үйлдээгүй ч дараах байдлаар холбогдож болзошгүй:

1. Бусдад өөрийн банкны данс болон төлбөрийн картыг ашиглуулах.
2. Хэн нэгний гуйлтаар эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгө, мөнгийг шилжүүлэх, хүлээн авах.

◆ Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл анги. Мөнгө угаах гэмт хэрэг
1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

◆ 2. Энэ гэмт хэргийг:
2.1 энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;
2.2 байнга тогтвортой үйлдэж;
2.3 албан тушаалтан албан чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.



www.police.gov.mn



www.mongolbank.mn



www.sankhuugiinbolovsrol.mn



